



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



TA-6883 REG: Accelerating Gender Equality in
East Asia for an Inclusive and Green Recovery

ТОЙРОГ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ: АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАР СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ ТАЙЛАН

МОНГОЛ УЛС
2024 ОН

ТАЛАРХАЛ

Энэхүү судалгааны хүрээг тодорхойлох болон судалгааг гүйцэтгэх бүх шатанд удирдамж, чиглүүлэг, үнэ цэнтэй зөвлөгөө дэмжлэг үзүүлж байсан Азийн Хөгжлийн Банкны Нийгмийн хөгжил, жендэрийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Цолмон, мөн бүсийн Төслийн зохицуулагч Ж.Чойханд нарт судалгааны багийн зүгээс талархлаа илэрхийлье. Судалгааны бэлтгэл ажлаас хэрэгжүүлэх шат хүртэл чухал дэмжлэг үзүүлж, төслийг бүхэлд үр дүнтэй байлгах үүднээс зөвлөгөө, мэдээллээр хангаж буй БОАЖЯ-ны Байгалийн нөөцийн бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Уранчимэг, агаар орчны бохирдол хариуцсан, ахлах шинжээч Ц.Мөнхбат болон жижиг, дунд бизнес эрхлэгч нараас мэдээлэл цуглуулахад дэмжлэг үзүүлсэн аймаг, дүүргийн жижиг, дунд үйлдвэрийн газрын мэргэжилтнүүдэд талархал илэрхийлье.

Мөн судалгаанд оролцож, өөрсдийн түүх, туршлага, тулгамдаж буй асуудлаа хуваалцсан нийт жижиг, дунд бизнес эрхлэгч нартаа мөн талархлаа.

Зөвлөх үйлчилгээний баг

ТАЙЛАНГИЙН ТУХАЙ

IRIM Судалгааны хүрээлэн, Монголын Тогтвортой Санхүүжилтийн Холбоо, Хөгжлийн Шийдэл ТББ-ын хамтарсан зөвлөх үйлчилгээний баг нь Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яамны захиалгаар хэрэгжүүлж буй "Тойрог Эдийн Засаг (ТЭЗ) ба Ногоон Бизнесийн Чиглэлд Бичил, Жижиг Дунд Бизнес Эрхлэгчдийг чадавхжуулах" зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр шалгарч, 2022 оны 11-р сараас 2025 оны 6-р сарын хооронд хэрэгжүүлж байна.

Зөвлөх үйлчилгээний хүрээнд аялал жуулчлалын салбарын тойрог эдийн засгийг дэмжсэн бодлогын орчин, хууль эрх зүйн актуудад дүн шинжилгээ хийх, тойрог эдийн засгийг нэвтрүүлэх боломж, хүндрэл бэрхшээлийн талаар үнэлгээ хийж, цогц үнэлгээний тайлан боловсрууллаа.

Хураангуй тайлан нь "Ногоон болон Тойрог эдийн засгийн цогц үнэлгээ" -ний тайланд туссан гол үр дүн, санал зөвлөмжийн хураангуйлсан хувилбар болно.

Зохиогчийн эрх

Азийн Хөгжлийн Банк (АХБ)

Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яам (БОАЖЯ)

Мэдэгдэл

Энэхүү зөвлөх үйлчилгээг Азийн Хөгжлийн Банкны санхүүжилттэй "TA-6883 REG: Accelerating Gender Equality in East Asia for an inclusive and Green Recovery" бүсийн төслийн хүрээнд хийж гүйцэтгэв.

Тус тайланд тусгагдсан агуулга, саналууд нь АХБ болон БОАЖЯ-ны байр суурийг илэрхийлэхгүй болно.

АГУУЛГА

Зураг, Хүснэгтийн жагсаалт	5
Товчилсон үг	5
1. Танилцуулга	6
2. Үндэслэл	8
3. Бодлогын үнэлгээ	11
4. Бэлэн байдлын үнэлгээ	16
5. Оролцогч талуудын үнэлгээ	28
6. Дүгнэлт	33
7. Зөвлөмж	40

ЗУРАГ, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн бүрэлдэхүүн хэсэг, логик хүрээ.....	7
Зураг 2. ТЭЗ-ийн үндсэн стратеги, ТЭЗ-ийг дэмжих бодлогын арга хэрэгслүүдийг багтаасан цогц загвар	10
Зураг 3. Аялал жуулчлалын салбарын нэмүү өртгийн сүлжээ.....	18
Зураг 4. Бэлэн байдлын үнэлгээний хураангуй.....	21
Зураг 5. Монгол Улсын аялал жуулчлалын салбарын оролцогч талуудын зураглал	30
Зураг 6. ТЭЗ-ийн таатай орчныг бүрдүүлэх хүчин зүйлс.....	40
Хүснэгт 1. ТЭЗ-ийн үндсэн стратегийн дагуу судалгааны гол үр дүнгийн хураангуй	27
Хүснэгт 2. Оролцогч талуудыг оноогоор үнэлэх шалгуур	29
Хүснэгт 3. Оролцогч талуудын шинжилгээний дүгнэлт	32
Хүснэгт 4. Монгол Улсын аялал жуулчлалын салбарт ТЭЗ-ийг нэвтрүүлэх бодлогын зөвлөмж	41

ТОВЧИЛСОН ҮГ

ААН	Аж Ахуйн Нэгж
ДНБ	Дотоодын Нийт Бүтээгдэхүүн
ЖДҮ	Жижиг Дунд Үйлдвэрлэл
МҮХАҮТ	Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим
НӨАТ	Нэмэгдсэн Өртгийн Албан Татвар
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ТББ	Төрийн Бус Байгууллага
ТЭЗ	Тойрог Эдийн Засаг
ХХААХҮЯ	Хүнс Хөдөө Аж Ахуй Хөнгөн Үйлдвэрийн Яам



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУРЧИЛАЛЫН
ЯАМ



ТОЙРОГ ЭДИЙН ЗАСАГ БА Н ЧИГЛЭЛД БИЧИЛ, ЖИЖ ЭРХЛЭГЧДИЙГ ЧАДАВХЖУУЛА

Төслийн эхлэлтийн с

2022/11/29

НЭГ. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

НЭГ. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Азийн Хөгжлийн Банк (АХБ) COVID-19 цар тахлын дараах жендерийн оролцоотой ногоон бизнесийг дэмжих чиглэлд БНХАУ болон Монгол Улсад бүс нутгийн техникийн туслалцааны төслийг санхүүжүүлж байгаа билээ. Энэ хүрээнд "Тойрог Эдийн Засаг (ТЭЗ) ба Ногоон Бизнесийн Чиглэлд Бичил, Жижиг Дунд Бизнес Эрхлэгчдийг чадавхжуулах" зөвлөх үйлчилгээний төсөл хэрэгжиж байгаа ба энэ нь хоол хүнс, сав баглаа боодол, аялал жуулчлалын салбар дахь эмэгтэй эзэнтэй болон эмэгтэй удирдлагатай Бичил, Жижиг, Дунд Бизнес Эрхлэгчид (цаашид бизнес эрхлэгчид)-ийн тойрог эдийн засаг (ТЭЗ), ногоон технологийн талаарх мэдлэг чадавхыг бэхжүүлэх замаар цар тахлын дараах хямралыг даван гарах, бизнесээ сэргээж, тогтвортой ногоон сэргэлтийг бий болгоход нь дэмжлэг үзүүлэх зорилготой. Зөвлөх үйлчилгээ нь дараах үндсэн 3 бүрэлдэхүүн хэсэгтэй. Төслийн бүрэлдэхүүн хэсгүүдийн дэлгэрэнгүйг (Зураг 1) -ээс харна уу.

1. Цогц үнэлгээ: ТЭЗ-ийг дэмжсэн бодлогын орчин, хууль эрх зүйн баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийн зорилтот салбарын эмэгтэй бизнес эрхлэгчдээс судалгаа авч ТЭЗ-ийн туршлагыг нэвтрүүлэх хэрэгцээ, бэлэн байдал, боломж, хүндрэл бэрхшээл, талуудын оролцоо хамтын ажиллагааны талаар цогц үнэлгээ хийж, тайлан боловсруулах.

2. Чадавх бэхжүүлэх хөтөлбөр: Үнэлгээний үр дүнд үндэслэн зорилтот салбарын бизнес эрхлэгчдийн ТЭЗ-ийн талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлж, чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх.

3. Бодлогын хэлэлцүүлэг: Дээрх үнэлгээ, чадавх бэхжүүлэх хөтөлбөрийн үр дүнд суурилан үндэсний болон олон улсын түвшинд бий болсон үр дүнгийн талаарх мэдээлэл, туршлага солилцож, бодлогын хэлэлцүүлэг хийх.

Цогц үнэлгээ нь "Бодлогын үнэлгээ", "Бэлэн байдлын үнэлгээ", "Оролцогч талуудын үнэлгээ" гэсэн гурван үндсэн хэсгээс бүрдэнэ.

Зураг 1. Төслийн бүрэлдэхүүн хэсэг, логик хүрээ.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО	Аялал жуулчлалын салбар дахь хоол хүнс болон сав баглаа боодлын чиглэлд дэх тойрог эдийн засаг, ногоон технологийн талаарх мэдлэг, чадавхыг бэхжүүлэх замаар жендерийн тэгш байдлыг дэмжих					
Үр дүн (Бүтээгдэхүүн)	1. МУ-ын тодорхой салбаруудад тойрог эдийн засгийн хандлагыг хэрэгжүүлэх боломж, саад бэрхшээлийн талаар цогц үнэлгээг хийж гүйцэтгэх.		2. Зорилтот салбарын бизнес эрхлэгчдийн тойрог эдийн засгийн талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлж, чадавхыг бэхжүүлэх.		3. Үндэсний болон ОУ-ын түвшний бодлогын хэлэлцүүлэг, туршлага солилцох арга хэмжээг зохион байгуулах.	
Гол үйл ажиллагаа	1.1. Тойрог эдийн засгийн чадавхын өнөөгийн нөхцөл байдлыг үнэлэх, хэрэгцээ тодорхойлох судалгааг хийх.	1.2. Зорилтот салбарт тойрог эдийн засгийн хандлагыг нэвтрүүлэх, өргөжүүлэхэд чиглэсэн бодлогын үнэлгээ гүйцэтгэх.	2.1. Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг ногоон бизнесийн туршлагыг ашиглах талаар мэдлэгийг нэмэгдүүлэх.	2.2. Ногоон бизнесийн талаар шилдэг шийдэл бүхий 15 бизнес эрхлэгчдэд зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлэх.	3.1. Ногоон болон тойрог эдийн засгийн талаар үндэсний түвшний бодлогын хэлэлцүүлэг зохион байгуулах.	3.2. Ногоон болон тойрог эдийн засгийн талаар олон улсын CAREC орнуудтай хэлэлцүүлэг зохион байгуулах.
Хийгдэх ажлууд	1.1.1. Бизнесийн өнөөгийн нөхцөл байдал, суурь үзүүлэлтүүд тодорхойлох 1.1.2. Сургалт, ментор, дэмжлэгийн хэрэгцээ.	1.2.1. Бодлогын үнэлгээ 1.2.2. Оролцогч талуудын шинжилгээ 1.2.3. Салбарын үнэлгээ.	2.1.1. Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө 2.1.2. Сургалт 2.1.3. Сургалтын өмнөх, дараах үнэлгээ 2.1.4 Үр дүнгийн үнэлгээ.	2.2.1. Сонгон шалгаруулалтын удирдамж 2.2.2. Сонгон шалгаруулалт 2.2.3. Менторын хөтөлбөр. 2.2.4. Шалгарсан бизнес эрхлэгч нарт грантын дэмжлэг	3.3.1.Бодлогын хэлэлцүүлэг зохион байгуулах бэлтгэл ажлууд 3.3.2. Үндэсний бодлогын хэлэлцүүлэг.	3.2.1. Виртиул хэлэлцүүлэг 3.2.2. CAREC-ийн сонгосон улс руу туршлага судлах аялал. Хэлэлцүүлэг болон туршлага солилцох аяллын үр дүнд тулгуурлан хэвлэн нийтлүүлэх мэдлэгийн бүтээгдэхүүн боловсруулна.

Аялал жуулчлалын салбар дахь байгаль орчны асуудал

Монгол Улсын аялал жуулчлалын салбар ДНБ-ий 6.7%-ийг, хөдөлмөр эрхлэлтийн 7.2%-ийг бүрдүүлж, нийт 1.8 их наяд төгрөг (ойролцоогоор 670 сая ам. доллар)-ийн орлоготой ажилладаг Монгол Улсын эдийн засгийн чухал салбар юм. Эдийн засгийн бусад салбарын адилаар аялал жуулчлалын үйл ажиллагаа нь хог хаягдал гаргадаг ч алслагдмал, байгалийн үзэсгэлэнт газруудад хог хаягдал бий болдог гэдэг утгаараа асуудал нь илүү төвөгтэй ба нөгөө талаас олон улсын жуулчид байгальд ээлтэй байдлаар аялахыг илүүд үзэх болсон. Монголын аялал жуулчлалын салбар нь улирлын чанартай бөгөөд 2019 онд зочилсон гадаад жуулчдын 70% нь оны дундуур буюу 2, 3-р улиралд (4-9-р сар) ирсэн байна. Мөн дотоодын аялагчдын 90.9% нь хувийн машинаар, 60.2% хувийн майхандаа байрлан зориулалтын бус газарт буудалладаг нь байгаль орчны бохирдол, ялангуяа хог хаягдлыг цуглуулах, боловсруулахад хүндрэл учруулдаг (МИРИМ Консалтант ХХК, 2022). Дотоодын жуулчид жилд 2500 орчим тонн хог хаягдал гаргадаг бол гадаадын жуулчид 4000 орчим тонн хог хаягдал гаргадаг гэсэн тооцоо бий (Байгаль орчны мэдээллийн төв, 2021). Харин өнөөгийн дэд бүтэц болон аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэгчид оргил ачааллын үед аялагчдын урсгал, түүнээс

дагалдан үүсэх хог хаягдлыг зохицуулах боломж хангалттай бүрдээгүй байна.

Улсын хэмжээнд жилд 2.2 сая тонн хоёрдогч түүхий эд гардгийн 58.2% нь орон нутагт, 41.8% нь Улаанбаатар хотоос гарч байна. Үүнээс нийт хог хаягдлын 3-5%-ийг дахин боловсруулж байна. Харин хуванцар бүтээгдэхүүний хаягдлын 6%-ийг дахин боловсруулж байна. 2021 оны байдлаар, хог хаягдал дахин боловсруулдаг 40 үйлдвэр, ялган бэлтгэдэг 160 гаруй цэг, түүнд 1,500 гаруй ажилтан ажиллаж байна. Дахин боловсруулах үйлдвэрлэлийн салбарыг статистикийн дагуу резин болон хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл гэсэн хоёр хэсэгт ангилж, тоон мэдээллийг нэгтгэдэг. Салбарын үйлдвэрлэлийн хэмжээ 2020 оны байдлаар 14.1%, борлуулалтын хэмжээ 15.5 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оноос хоёр дахин буурсан үзүүлэлт юм.

Монгол Улсад хаягдал боловсруулах тохиромжтой технологи, үйлдвэр хомс учраас хог хаягдал, ялангуяа хуванцар, шил, гялгар уутнаас үүдэлтэй хаягдлыг боловсруулах сорилттой тулгараад байгаа ч хуванцар сав, гялгар уут, хатуу хуванцар савны хаягдлын 8.9%-ийг боловсруулж байгаа нь ахиц юм.

Монгол Улсын аялал жуулчлалын салбар дахь ТЭЗ-ийн өнөөгийн байдал, сорилт

Монгол Улсын аялал жуулчлалын салбарт үйлдвэрлэл эрхэлдэг нийт 742 бизнес эрхлэгчдийг хамруулсан судалгаагаар хүнс, ус ундаа үйлдвэрлэгчид байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулах туршлага дутмаг, энэ төрлийн арга замуудыг

нэвтрүүлэх зорилт, төлөвлөгөө, төсөв ер нь байдаггүй, ТЭЗ-ийг хэмжих гол үзүүлэлтүүд нэвтрээгүй байна. Ерөнхийдөө бизнес эрхлэгчдийн дунд байгууллагын худалдан авалт буюу бүтээгдэхүүний түүхий эд, орц найрлагын бэлтгэн нийлүүлэгчдэд

тодорхой шаардлага тавьж, хэрэгцээгүй, эдийн засгийн хэмнэлт багатай, байгаль орчинд сөрөг нөлөөтэй худалдан авалтаас татгалзах хандлага харьцангуй төлөвшиж байна. Засвар үйлчилгээ, байнгын цэвэрлэгээг зохих түвшинд дотооддоо хэрэгжүүлэх байдал сайн боловч хүрээлэн буй орчин, нийгэмд учруулах сөрөг нөлөөг бууруулах технологийн чадвар сул. Бараа бүтээгдэхүүнээ дахин загварчлах, дахин бодох туршлага хангалтгүй. Хог хаягдлыг цуглуулах, ангилах, дахин боловсруулах талаар сургалт, зөвлөх үйлчилгээнд зөгийн аж ахуй бусад салбараас илүү хамрагддаг ба үүний дараа хүнс, ус ундаа үйлдвэрлэгчид орж байна.

Ийнхүү аялал жуулчлалын салбарт хүнс, ус ундаа, сав баглаа боодол нийлүүлдэг аж ахуйн нэгж (ААН)-үүдийн ТЭЗ-ийн ойлголт, хандлага дутмаг, ТЭЗ-ийн зарчмуудыг хэрэгжүүлэх хүний нөөц, санхүүжилт, технологийн чадавх дутмагаас энэ салбарын үйлчилгээг дагасан хог хаягдал тасралтгүй гарсаар байна. Хог хаягдлыг бууруулах өнөөгийн үндсэн стратеги нь ТЭЗ-ийн зарчмуудын хамгийн эцсийн сонголт болох үүссэн хог хаягдлыг дахин боловсруулахад чиглэж байгаа ч алслагдсан нутагт хог ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах цэгт тушаах нь хүндрэлтэй. Аялал жуулчлал нь байгальд түшиглэсэн үйлчилгээ үзүүлдэг гэдэг утгаараа энэ салбарын ханган нийлүүлэгчид бусад салбартай харьцуулахад хүрээлэн буй орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулж, ТЭЗ-ийн зарчмуудыг тодорхой хэмжээнд хэрэгжүүлэхээр зорьдог. Ялангуяа жуулчны баазууд байгальд сөрөг нөлөөгүй, хог хаягдал бага, нөөцийн хэмнэлттэй шийдлүүдийг байнга эрэлхийлдэг. Зарим жуулчны бааз худалдан авалтын түвшинд "дахин бодох" (rethink) зарчмаар ус ундааны шил саваа буцаан татдаг ханган

нийлүүлэгчдээс худалдан авалт хийдэг. Мөн жуулчны улирал эхлэхэд аялал жуулчлалын тур операторууд болон хоол, хүнс, байраар хангах үйлчилгээ үзүүлдэг компаниуд бүх ажилтандаа хог хаягдлын менежментийн сургалт хийдэг.

Аялал жуулчлалын салбарт бизнес эрхлэгчдийн ихэнх нь жижиг, дунд бизнес эрхлэгчид төдийгүй, жуулчдын цаашдын хэрэгцээ, сонирхолд нийцүүлэн ТЭЗ-ийн туршлагыг нэвтрүүлэхэд тодорхой сорилтуудтай тулгарч байна. ТЭЗ ба ногоон бизнесийн чиглэлд бизнес эрхлэгчдийг чадавхжуулах энэхүү зөвлөх үйлчилгээний хүрээнд хийгдсэн бэлэн байдлын үнэлгээний судалгааны үр дүнд бизнес эрхлэгчид ТЭЗ-ийг нэвтрүүлэхэд дараах асуудлууд хамгийн ихээр тулгардаг гэж үзсэн. Тодруулбал, (1) эдийн засаг, санхүүгийн нөөц дутмаг, дэмжлэг авах боломж хязгаарлагдмал, (2) хөрөнгө оруулалт дутмаг, (3) байгальд ээлтэй технологийн сүүлийн үеийн хөгжил, ТЭЗ-ийн талаарх дэлхий, бүс нутаг, үндэсний чиг хандлагатай холбоотой мэдээллийн хүртээмж бага, (4) ТЭЗ, түүнийг хэрэгжүүлэх дизайн, стратеги, шийдэлтэй холбоотой мэдээлэл дутмаг гэжээ. Монгол Улсын Засгийн газраас хөнгөлөлт, урамшуулал, НӨАТ, гаалийн татвар, орлогын албан татварын тодорхой хувийг чөлөөлөх зэрэг хөнгөлөлтийг үр тариа, хүнсний ногоо тариалан, мал аж ахуйн салбарт түлхүү олгодог бол, сав баглаа боодол болон хоол хүнсний үйлдвэрлэлийн салбарт харьцангуй бага хөнгөлөлт урамшуулал батлагджээ (Дэлхийн банк, 2022).

Энэхүү судалгаагаар зорилтот салбарын бизнес эрхлэгчдийн ердөө 6.5% нь "ТЭЗ-ийн талаар "сайн мэднэ", 66.8% нь "сонсож байсан", 26.8% нь "огт сонсож байгаагүй" гэж хариулсан.

Тэдний ихэнх нь ТЭЗ-ийн талаар хязгаарлагдмал ойлголттой ба үүн дотроос хог хаягдлын менежментэд түлхүү анхаарал хандуулдаг аж. Бизнес эрхлэгчид ТЭЗ-ийг бизнесийн үйл ажиллагаандаа нэвтрүүлэх сонирхол өндөр байгаа нь судалгааны дүнгээр харагдсан хэдий ч энэ талаарх ойлголт, мэдлэг дутмагаас хаанаас, хэрхэн эхлэхээ мэдэхгүй байна. Мөн үүнд санхүүгийн нөөц, урсгал зардал ихээр шаарддаг гэсэн түгээмэл ойлголт нь тодорхой алхам хийхэд саад болж байна. Энэхүү мэдээллийн зөрүү нь бусад салбарын бизнесүүдтэй хамтран ажиллах, хог хаягдлын менежментийг сайжруулах боломжийг хязгаарлаж байна.


ЖДУ, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих бодлогод ТЭЗ-г дэмжих заалтууд хангалттай тусгагдаагүй. Монгол Улсаас НҮБ-д тайлагнадаг “Үндэсний сайн дурын илтгэл”-д үйлдвэрлэл, үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах тал дээр сүүлийн жилүүдэд маш бага ахиц гаргасан гэж дурджээ. Мөн хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах зэрэг үйл ажиллагаанд

төрөөс ямар нэгэн онцгойлсон татварын хөнгөлөлт, урамшуулал байдаггүй. Мөн хог хаягдлыг бууруулах чиглэлээр төр, хувийн хэвшил, мэргэжлийн байгууллага хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагаа сул зэрэг асуудлыг дурдаж болно.

Энэхүү судалгааны арга зүйн гол үндэс нь дараах ТЭЗ-ийн загвар юм (**Зураг 2**). ТЭЗ-ийн стратегийг боловсруулахад байгаль орчин ээлтэй шийдэл болон бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн ойлголтыг хамтад нь авч үзэх шаардлагатай. ТЭЗ-ийг нэвтрүүлэх бэлэн загваруудад дүн шинжилгээ хийсний үндсэн дээр дараах зургаан стратегийг нэрлэж болохоор байна. Үүнд:

- Нөөцийн үр ашгийг нэмэгдүүлэх
- Бүтээгдэхүүний хэрэглээг уртасгах
- Үйлчилгээнд суурилсан загвар руу шилжих
- Хаягдлын дараа нөхөн сэргээх
- Нийлүүлэлтийг тойрогт оруулах
- Тойрог бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлтийг хангах

Зураг 2. ТЭЗ-ийн үндсэн стратеги, ТЭЗ-ийг дэмжих бодлогын арга хэрэгслүүдийг багтаасан цогц загвар.





ГУРАВ. БОДЛОГЫН ҮНЭЛГЭЭ

Бодлогын үнэлгээний гол зорилго нь аялал жуулчлалын салбар, тэр дундаа хоол хүнс, сав баглаа боодлын салбарт төрөөс баримталж буй бодлого, хөгжлийн зорилтууд нь ТЭЗ-ийн хандлага, зарчмуудтай хэрхэн уялдаж буйг тодорхойлж, ТЭЗ-ийг дэмжих зорилтуудыг хэрэгжүүлэх бодлогын механизмууд, тэдгээрийн үр нөлөө, өнөөгийн салбарын нөхцөлд хэр нийцтэй, тохиромжтой байгааг судлах замаар шийдвэр гаргагчдад суурь мэдээллийг бүрдүүлж өгөх зорилготой. Монгол Улс урт хугацааны ногоон хөгжлийн бодлогоо тодорхойлсон ба энэ хүрээнд Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж байна. Тэдгээрт ТЭЗ гэсэн ойлголтыг шууд дурдаагүй ч байгаль орчинд ээлтэй, үр ашигтай хэрэглээ, дэвшилтэт ногоон технологийг эдийн засгийн хөшүүргээр дэмжих, төрийн худалдан авалтыг ногоон худалдан авалт руу аажмаар шилжүүлэх, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулж буй хувийн хэвшлийг дэмжих тогтолцоог бий болгох зэрэг ТЭЗ-ийн зарчмуудыг бусад асуудалтай хавсран оруулжээ (МУЗГ, 2019). Одоогоор “Алсын хараа-2050” хөгжлийн урт хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн талаарх албан ёсны нэгдсэн тайлан, статистик мэдээ гарч эхлээгүй байна.

Монгол Улс илүү тодорхой шалгуур үзүүлэлт болоод илүү боловсронгуй эрхзүйн зохицуулалтыг хэрэгжүүлснээр ТЭЗ-ийг дэмжих тусгайлан бодлогын хэрэгсэлтэй болох боломжтой. Тухайлбал, “Алсын хараа-2050”-д 2021-2025 он хүртэлх таван жилийн хөгжлийн төлөвлөгөөний хүрээнд ногоон худалдан авалтыг төрийн нийт худалдан авалтын

20 хувьд хүргэхээр тусгажээ. Гэсэн хэдий ч ТЭЗ-ийг дэмжих зохицуулалт, бодлогын орчин хангалтгүй хэвээр байна. Төрийн худалдан авах ажиллагааны 2022 оны стратеги төлөвлөгөөнд тогтвортой, ногоон худалдан авалттай холбоотой зорилт, үйл ажиллагааны тодорхой стратеги дутмаг байна. Бичгийн цаас, хэвлэгч машины бэх, хөнгөн бетон блок зэрэг бүтээгдэхүүний хувьд ногоон худалдан авалтын шалгуур үзүүлэлт цахим орчинд бэлэн байгаа ч тэдгээрийг төрийн худалдан авалтын цахим системд оруулаагүй байна. Мөн ногоон худалдан авалтыг төрийн нийт худалдан авалтын 20 хувьд хүргэх зорилтын хүрээнд гарсан ахиц хараахан мэдээлэгдээгүй. Түүнчлэн Сангийн яамны Худалдан авах ажиллагааны газраас төрийн ногоон худалдан авалтыг дэмжих зорилгоор 11 нэр төрлийн бүтээгдэхүүний үзүүлэлтийг боловсруулж байгаа ч хуулийн зөвшөөрөл хүлээгдэж байгаа тул одоогоор дэлгэрэнгүй мэдээлэл хомс байна.

Монгол Улсын Байгаль орчны зорилтот хөтөлбөр нь 2020 онд батлагдсан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан хөгжлийн долоон хөтөлбөрийн нэг юм. ЖДҮ-ийг дэмжих тухай хуульд янз бүрийн хүчин зүйлийг харгалзан технологийн дэвшил, шинжлэх ухааны судалгааг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэхийг чухалчилж, хортой технологи ашигласан, байгаль экологид хохирол учруулсан ААН-үүдэд хариуцлага тооцохоор тусгасан (УИХ, 2022).

“Ногоон зээлийн сан” хөтөлбөр нь ЖДҮ эрхлэгчдэд өндөр хүртээмжтэй, байгаль орчинд ээлтэй, агаар, орчны бохирдол, дулааны алдагдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн, цахилгаан халаагуур худалдан авахад

дэмжлэг үзүүлэх зорилготой бага хүүтэй зээлийн бүтээгдэхүүн бөгөөд энэ нь ТЭЗ-ийг дэмжих бодлогын чухал хэрэгсэл юм. Тухайлбал, био жорлон, жижиг оврын цэвэрлэх байгууламж зэрэг хөрсний бохирдлыг бууруулахад зориулсан зээлийн жилийн хүү 2% байна.

Бодлогын орчинд дутагдаж буй орон зайг дараах байдлаар тодорхойлов.

Үүнд:

1. Байгаль орчны зорилтот хөтөлбөрт ТЭЗ-ийг дэмжсэн агуулгууд цогц байдлаар орсон хэдий ч өнөөг хүртэл батлагдаагүй байгаа нь ТЭЗ-ийг дэмжсэн үйл ажиллагааг хойш татаж байна.
2. Орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт хангалттай ил тод бус (жишээ нь, 2020-2023 жилийн төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэлийн үнэлгээ Засгийн газарт тайлагнасан хэрэгжилтийн тайлангууд, 2019 онд дууссан 1-р үе шатны үнэлгээний тайлан, г.м.)
3. ЖДҮ-ийг дэмжих бодлого болон хөнгөлөлтэй зээл гэх мэт эдийн засгийн хэрэгслүүд байгаа хэдий ч бизнес эрхлэгчдийг ТЭЗ-ийн туршлагыг хэрэгжүүлэхэд дэмжлэг болохуйц шат дараатай (ногоон үйлдвэрлэл, хог хаягдлын менежмент, г.м) хөшүүрэг бүрдээгүй байна.

Тиймээс хөнгөлөлттэй ногоон зээлийн үр дүн, статистикийг нэгтгэн гаргаж ил тод тайлагнах, ногоон бүтээгдэхүүний шалгуур үзүүлэлтийг боловсруулах, хэрэглэгчийн байгаль орчинд ээлтэй сонголт хийх, тогтвортой байдлыг дэмжих ногоон шошгожуулалтын системийг бүрдүүлэхэд хувийн хэвшил, мэргэжлийн холбоод, иргэдтэй хамтран ажиллахыг зөвлөмж болгож байна.

Аялал жуулчлалын салбарт бизнес эрхлэгчид өөрсдийн онцлог, үйлчилгээний төрлөөс хамааран дагаж мөрдөхөөр заасан нийт 15 MNS стандарт байдгаас ТЭЗ-ийн агуулга түлхүү багтсан 2 стандарт бий. Үүний нэг нь “Амралтын газар, жуулчны баазад тавих ерөнхий шаардлага (MNS 6043 : 2019)” буюу нэг ээлжид 20-оос дээш хүн хүлээх авах хүчин чадалтай амралтын газар, жуулчны баазуудын байгалийн болон соёлын өвийн дурсгалт газар, голын хамгаалалтын бүс, усны эх үүсвэр, ойн сан хүртэлх зайн хамгийн доод хэмжээг зааж өгсөн байдаг. Эдгээр амралтын газрууд байгальд сөрөг нөлөөгүй, байгалийн унаган төрхийг алдагдуулахгүйгээр үйл ажиллагаа явуулах ба эрчим хүчний хэрэглээний 20-оос багагүй хувийг сэргээгдэх эрчим хүчээр хангасан байх шаардлагатай (Стандарт, хэмжил зүйн үндэсний газар, 2019). Мөн “Тусгай хамгаалалттай газар нутаг дахь эко аялал жуулчлалын зориулалттай байр сууц, үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлага (MNS 6426 : 2013)” нь тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлж буй байгууллага, иргэдэд заавал биелүүлэх үүрэг буюу хог хаягдлын шаталтаар дулаан үйлдвэрлэх бичил систем, хийн хөдөлгүүр, дундын үүсгүүр зэрэг тоног төхөөрөмж нэвтрүүлэх шаардлага тавьдаг. Эрчим хүчний хэрэглээний 30-аас багагүй хувийг сэргээгдэх эрчим хүчээр хангах ёстой. Түүнчлэн богино зайн аялалд унадаг дугуй, хөсөг тэрэг ашиглах, нэг удаагийн эд зүйлсийг дахин ашиглах боломжтой бүтээгдэхүүнээр солих, байгаль орчинд ээлтэй технологийг дэмжих, ус, цахилгааны хэмнэлтийн талаарх сурталчилгааны материал түгээх, хог хаягдлыг бууруулах, саарал усыг дахин ашиглах зэргийг стандартад тусгажээ. Мөн хог хаягдал цуглуулах цэгүүдэд хөрсний бохирдлоос сэргийлэх үүднээс хогийг 3-4 төрлөөр

ангилаан ялгадаг байх шаардлага багтсан (Стандарт, хэмжил зүйн үндэсний газар, 2013).

Монгол Улсын Засгийн газраас аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх, сэргээхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор шинэчлэгдэн батлагдсан “Стратегийн төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”-ын (2020 оны 216 дугаар тогтоол) хүрээнд тогтвортой хөгжлийн зарчмуудыг удирдлага болгон аялал жуулчлалын тогтвортой хөгжил, хамтын ажиллагааг дэмжих төлөвлөгөө гаргасан ба 2024 он гэхэд тодорхой үр дүнд хүрэхээр зорьж байна. Гэвч энэхүү төлөвлөгөө нь Засгийн газрын тогтоол эсвэл салбарын асуудал эрхэлсэн сайдын тушаал зэргээр албан ёсоор батлагдаагүй бөгөөд төлөвлөгөө болон хэрэгжилттэй холбоотой албан ёсны тайлан, хяналт шинжилгээ үнэлгээний тайлан олон нийтэд ил тод болоогүй байна.

Бодлогын орчинд дутагдаж буй орон зайг дараах байдлаар тодорхойлов.

Үүнд:

1. “Тогтвортой аялал жуулчлал”-ын тодорхойлолт, стандарт, нарийвчилсан шалгуур үзүүлэлтүүд тодорхой бус.
2. Тогтвортой аялал жуулчлал, ТЭЗ-ийн туршлагын талаар сургалт мэдээллийн ажлууд дутмаг бөгөөд тусгайлан чиглэл өгч төсөв батлагдаагүй.
3. Бүсийн болон орон нутгийн түвшний зохицуулалт хангалтгүйгээс хэрэгжүүлэлт ерөнхийдөө сул.

Хүнсний салбарын хувьд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын стратеги төлөвлөгөө (2021-2024)-нд эдийн засаг, ногоон хөгжилтэй холбоотой цөөн заалт тусгагдсан. Мөн Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яам (ХХААХҮЯ)-наас зохистой арга технологиор үйлдвэрлэсэн

хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний гэрчилгээжүүлэлтийн журмыг баталж, тухайн байгууллагыг оюуны өмчид бүртгэхийг зөвшөөрсөн. Органик хүнсний бодлогын хүрээнд органик хүнсний үйлдвэрлэлийн стандарт нь хог хаягдлаас урьдчилан сэргийлэх, бууруулахад чиглэсэн хяналт, зохицуулалтын хэрэгсэл болдог. Органик бүтээгдэхүүний гэрчилгээ, шошго нь байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх нэг арга хэрэгсэл юм. Түүнчлэн, органик үйлдвэрлэл эрхлэгчдэд зориулсан урамшуулал нь ногоон эрчим хүчний үйлдвэрлэлд шилжихэд дэмжлэг үзүүлэх эдийн засгийн хөшүүрэг болж чадна. Тиймээс хөдөө аж ахуйг дэмжих, урамшуулах цогц бодлого боловсруулж, салбарын эцсийн зорилттой уялдуулж, хэрэгжилтийг хангах нь нэн чухал юм.

Хүнсний салбарт хэрэгжиж буй “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөн болон “Эдийн засгаа дэмжих 10 их наядын хөтөлбөр” зэрэг нь органик үйлдвэрлэлийг дэмжсэн агуулга тусгагдаагүй, органик үйлдвэрлэлийг 2030 он гэхэд хүнс хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 5 хувьд хүргэх зорилттой төдийлөн уялдаагүй. Түүнчлэн тус салбарын хууль тогтоол, хөтөлбөрүүдийн хүрээнд хэрэгжүүлж буй ажлуудад шууд болон шууд бус байдлаар ногоон эдийн засгийг дэмжсэн арга хэмжээ дутмаг байна.

Сав баглаа боодлын салбарын хувьд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Засгийн газарт чиглэл өгөх тухай 104 дүгээр зарлиг нь хүн амын аюулгүй байдлыг хангах үүднээс холбогдох байгууллагуудын хамтын ажиллагааг идэвхжүүлж, сав баглаа боодол, шошгожуулалтын асуудлыг тэргүүлэх чиглэлүүдийн нэг болгосон. Монгол Улсын Ерөнхийлөгчийн

Тамгын газар болон ХХААХҮЯ-аас сав баглаа боодлын үйлдвэрлэл эрхлэгчид, мэргэжлийн холбоодод “Хүнсний болон хүнсний зориулалтын сав баглаа боодлын үйлдвэрлэлийг дэмжих хөнгөлөлттэй зээл” олгож байгаа ч урамшууллын талаар нарийн тодорхойлолт үгүй байна. Монгол Улсын Засгийн газрын 189 болон 199 дүгээр тогтоолоор бүх төрлийн 0.035 мм болон түүнээс нимгэн, нэг удаагийн нийлэг хальсан уутыг худалдаа, үйлчилгээнд сав, баглаа боодлын зориулалтаар импортлох, үйлдвэрлэх, хэрэглэхийг хориглосон. Нийлэг уутны хэрэглээний хяналт дотоодын үйлдвэрүүдэд сайн боловч гаалиар орж ирж буй нийлэг уутан дээрх хяналтыг илүү сайжруулах шаардлагатай. Гэвч хууль эрх зүйн хувьд хэрэгжилт, нарийвчилсан заавар, чиглэл одоогоор дутмаг байна.

Монгол Улсын сав баглаа боодлын өнөөгийн чиг хандлагад “ногоон” буюу “биологийн задралд ордог” сав баглаа боодлын тодорхойлолт байхгүй, дахин боловсруулсан сав баглаа боодлын хувь хэмжээний талаар системтэй мэдээлэл бүрдээгүй байна. Түүнчлэн тус салбарын технологи, тоног төхөөрөмжийн талаарх мэдээлэл хангалтгүй. Тиймээс сав баглаа боодлын салбар импортын түүхий эдэд түшиглэж байгаа өнөөгийн нөхцөлд дотоодын сав баглаа боодлын үйлдвэрлэлийг идэвхжүүлэх арга хэмжээг Засгийн газрын 2021-2025 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулах нь нэн чухал.

Хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрүүдэд урамшуулал, гаалийн болон НӨАТ-ын хөнгөлөлт үзүүлээгүй, эко төлбөрийн тухай журам батлагдаагүй, технологийн шинэчлэл, хоггүй хэрэглээг дэмжих заалт хязгаарлагдмал, хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрүүдэд

дэмжлэг, урамшуулал олгодоггүй, түүнчлэн энэ салбарын ААН-үүдэд санхүүгийн болон зээлийн дэмжлэг дутмаг байгаа нь бодлогын орчинд үгүйлэгдэж буй орон зай юм.



**ДӨРӨВ. БЭЛЭН БАЙДЛЫН
ҮНЭЛГЭЭ**

4.1 ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ



Бэлэн байдлын үнэлгээ нь аялал жуулчлалын салбарын нэмүү өртгийн сүлжээнд оролцогч талууд болох хоол хүнс, ус ундаа, байраар хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг үйлдвэрлэгч болон үйлчилгээ үзүүлэгчдийн ТЭЗ-ийн стратеги, шийдлийг нэвтрүүлэхэд бэлэн эсэхийг үнэлсэн шинжилгээний дүн юм.

Аялал жуулчлалын салбарын бизнес эрхлэгчдийн хоол хүнс, сав баглаа боодолтой холбоотой тойрог эдийн засгийн асуудлыг судалж буй учраас салбар дундын асуудлыг судлах болно.

Нөгөө талаас эдгээр салбарын асуудлуудыг нэг бүрчлэн нарийвчлан судлах боломжгүй хэдий ч аялал жуулчлалын салбар дах хоол хүнс, сав баглаа боодол, хог хаягдал, бизнес эрхлэгчдэд ТЭЗ-ийг нэвтрүүлэхэд аль салбарт ямар асуудал, боломж байгааг илүүтэй анхаарах юм.


Аялал жуулчлалын салбарын зах зээлийн гинжин хэлхээнд оролцогч талуудаас Байраар хангах үйлчилгээ үзүүлдэг болон хоол хүнс, ус ундааны салбарт үйл ажиллагаа явуулж буй бизнес эрхлэгчдийг хамруулсан. (Зураг 3)

- **Байраар хангах үйлчилгээ үзүүлдэг бизнес эрхлэгчид:** Зочлох үйлчилгээ нь зочид буудал, амралтын газар, түр буудаллах байр болон бусад төрлийн байр гэх мэт жуулчдад шууд үйлчилдэг олон төрлийн бизнесийг хамардаг. Эдгээр бизнес нь жуулчдыг тав тухтай байлгах үүднээс буудал, хоол болон холбогдох үйлчилгээгээр хангадаг.
- **Хоол хүнс, ус ундааны салбарт үйл ажиллагаа явуулж буй бизнес эрхлэгчид:** Ресторан, кафе, баар, хүнсний үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгж нь жуулчдад хоолны үйлчилгээ санал болгох байдлаар аялал жуулчлалын салбарт хувь нэмрээ оруулдаг. Эдгээр нь орон нутгийн хоолыг таниулж, олон төрлийн хоол, ус ундааны сонголтыг бий болгож, аялагчдыг унд хоолоор хангах үйл явцад хувь нэмрээ оруулдаг. Мөн, үүнд сав баглаа боодол ашиглаж жуулчид, аялагчдад бүтээгдэхүүн, үйлчилгээ хүргэдэг аж ахуйн нэгжүүдэд багтана.

Үнэлгээнд зорилтот бүлгүүдийг гурван үндсэн сегмент болгон хуваасан ба эхний хоёр бүлэг нь “нийлүүлэлт тал”-ыг, гурав дахь бүлэг нь хэрэглэгч буюу “эрэлт тал”-ыг хамруулсан.

Үүнд нийлүүлэлт талаас “үйлдвэрлэгч” болон “үйлчилгээ үзүүлэгч” аль аль бүлгийг зорилтот бүлэг болгон авч үзсэн ба “эрэлт тал”-ыг төлөөлж аялагчдыг хамруулсан.

Зураг 3. Аялал жуулчлалын салбарын нэмүү өртгийн сүлжээ



Тодруулбал:

1. Хүнс, ус ундаа, сав баглаа боодол үйлдвэрлэгчид болон хоол үйлдвэрлэлдээ материал худалдан авдаг гуанз, ресторан зэрэг хүнсний үйлдвэрлэлийн ААН-үүдээс бүрдсэн “үйлдвэрлэгчдийн бүлэг” -ийн төлөөлөл болох нийт 222 бизнес эрхлэгчид хамрагдсан.

2. “Дундын хэрэглэгчид” буюу “үйлчилгээ үзүүлэгч” бүлэгт байраар хангах үйлчилгээ үзүүлэгч (зочид буудал, жуулчны бааз гэх мэт), хоол ундны үйлчилгээ үзүүлэгч (гуанз, ресторан, шөнийн цэнгээний газар, гудамжны хоолны цэг, кофе шоп гэх мэт), хүнсний дэлгүүр ажиллуулдаг 178 бизнес эрхлэгчид хамрагдсан.

3. Аялагчдаас бүрдэх “эцсийн хэрэглэгч”-ийн судалгаанд нийт 100 гаруй аялагч хамрагдсан.

Нийлүүлэлт талаас Улаанбаатар хот болон аялал жуулчлал харьцангуй хөгжсөн Архангай, Хөвсгөл аймагт аялал жуулчлал, хоол, хүнс болон сав баглаа боодлын салбарт идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй 400 бизнес эрхлэгчид хамрагдсан. Судалгааны мэдээлэлд шинжилгээ хийхдээ судалгаанд хамрагдсан оролцогчдыг 2 бүлэгт хуваасан ба эхний бүлэгт хоол хүнс, ус ундаа, сав баглаа боодол үйлдвэрлэдэг буюу “үйлдвэрлэгч тал”-ын төлөөлөл болох 222 бизнес эрхлэгчид хамрагдсан бол, хоёрдох бүлэгт, хоол үйлдвэрлэл (цайны газар, зоогийн газар), байраар хангах үйлчилгээ (зочид буудал, жуулчны бааз, гэх мэт), хоол, ус ундаагаар үйлчилдэг газрууд (шөнийн цэнгээний газар, түргэн хоол, кофе шоп, гэх мэт) болон хүнсний дэлгүүрүүд зэрэг “үйлчилгээ үзүүлэгч” буюу “дундын хэрэглэгч” гэж нэрлэгдэх 178 бизнес эрхлэгчид хамрагдсан.

Эхний хэсэгт бизнес эрхлэгчдийн ТЭЗ-ийн стратеги, шийдлийг нэвтрүүлэхэд бэлэн байдлыг (i) хөрөнгө (барилга, байгууламж, үл хөдлөх хөрөнгө), (ii) технологи, тоног төхөөрөмж, (iii) санхүү/хөрөнгө, (iv) тогтвортой байдалд чиглэсэн бизнесийн соёл, (v) бизнесийн дүр төрх, хүлээн зөвшөөрөгдөх байдал, (vi) хүний нөөцийн ур чадвар, (vii) бизнесийн тогтвортой байдлын стратеги, (viii) бодлого, судалгаа, бүтээгдэхүүн хөгжүүлэх чадвар, (ix) түншлэл болон хамтын ажиллагаа хөгжүүлэхэд бэлэн байдал, (x) түүхий эд ашиглахтай холбоотой бэлэн байдал (ялангуяа түүхий эдийн хэрэглээ өндөр), (xi) нягтлан бодох бүртгэлийн хүчин чадал, бэлэн байдал (нэгж бүтээгдэхүүний өртөг, үр ашгийн тооцоо, материалын зарцуулалт, хүний

нөөцийн зардал, гэх мэт) гэсэн 11 багц асуултын хүрээнд тодорхойлсон.

Харин хоёр дахь хэсэгт илүү бизнес эрхлэгчдэд чиглэсэн байдлаар үнэлгээ хийж, ТЭЗ-ийн үндсэн стратегиуд болох (i) нөөцийн үр ашгийг нэмэгдүүлэх, (ii) бүтээгдэхүүн ашиглалтын хугацааг уртасгах, (iii) үйлчилгээнд суурилсан загварт шилжих, (iv) хаягдлын дараа нөхөн сэргээх, (v) нийлүүлэлтийг тойрогт загварт шилжүүлэх, (vi) тойрог бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлтийг нэмэгдүүлэх гэсэн 6 стратегийг ангилал тус бүрээр, ТЭЗ-ийн мөчлөгийн холбогдох үе шатуудтай уялдуулан тодорхойлсон. ТЭЗ дахь бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн үе шатууд болох бүтээгдэхүүний (дахин) загварчлал, үйлдвэрлэл, хэрэглээ, хэрэглээний дараах үе, борлуулалт болон маркетинг, худалдан авалт зэргийг бүхэлд нь хамруулан авч үзсэн. Бизнес эрхлэгчид нь бүтээгдэхүүнийхээ амьдралын мөчлөгийн бүх үе шатанд идэвхтэй оролцсоноор тухайн бүтээгдэхүүн (болон холбогдох үйлчилгээ) үе шат бүрдээ эдийн засаг, байгаль орчин (уур амьсгал, экосистем, байгалийн гамшигт үзэгдэл), нийгэмд (ажил эрхлэлт, жендер) ямар нөлөө үзүүлэхийг тодорхойлох боломжтой. Үүний үр дүнд бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн үе шат бүрд гарах асуудлыг шийдвэрлэхэд тохирох ТЭЗ-ийн туршлагыг санал болгох боломжтой. Энэхүү үнэлгээнд ТЭЗ-ийн “9Р-ийн зарчим” буюу “татгалзах”, “дахин бодох”, “багасгах”, “дахин ашиглах”, “засварлах”, “шинэчлэх”, “дахин үйлдвэрлэх”, “өөр зориулалтаар дахин ашиглах”, “дахин боловсруулах”, “сэргээх” гэсэн зарчмуудыг зөвлөмж байдлаар ашигласан ба гол зорилго нь нийлүүлэлтийн сүлжээ болон бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн үе шат тус бүрд хэрэгжүүлж болох ТЭЗ-

ийн боломжит шийдлүүдийг тодорхойлж гаргахад чухал ач холбогдолтой байдаг.

ТЭЗ-ийг нэвтрүүлэхийн тулд ижил төстэй болон өөр салбарын бизнес эрхлэгчид түншлэл, хамтын ажиллагааны хүрээнд хоорондоо болон судалгааны байгууллагуудтай мэдлэг, туршлага солилцох боломжтой. Мөн, технологи, санхүүжилт, гаднын дэмжлэг, зөвлөх үйлчилгээ авч болно. Гэхдээ бизнес эрхлэгчдийн хувьд ТЭЗ-ийн туршлагыг хэрэгжүүлэхэд түлхэц өгөхүйц сэдэл, ялангуяа өөрчлөлтийг эхлүүлэх, идэвхтэй

арга хэмжээ авах хүсэл эрмэлзэл хамгийн чухал.

“Эрэлт тал” буюу эцсийн хэрэглэгчдийн хувьд, судалгаанд 100 жуулчин, аялагчид хамрагдсаны 20% нь сүүлийн хоёр жилд Монгол Улсад аялсан гадаадын жуулчид, 80% нь дотоодын аялагчид байна. Тэднээс аялал жуулчлалын байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн зан үйл болон дээр дурдсан ТЭЗ-ийн зургаан стратегийн дагуу ярилцлага судалгаа авсан.

4.2 ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

А. НИЙЛҮҮЛЭЛТ БУЮУ ҮЙЛДВЭРЛЭГЧ ТАЛ

ТЭЗ-ийн шийдлийг нэвтрүүлэхэд бизнес эрхлэгчид ТЭЗ болон тогтвортой хөгжлийн талаар тодорхой мэдлэгтэй байх нь чухал. Бэлэн байдлын үнэлгээний үр дүнгээс харахад судалгаанд хамрагдсан үйлдвэрлэгчдийн 6.5% нь ТЭЗ болон ногоон хөгжлийн тухай сайн мэддэг бол 66.8% нь энэ талаар бага зэрэг ойлголцогтой буюу сонсож байсан. Харин судалгаанд оролцсон үйлдвэрлэгчдийн 26.8% нь ТЭЗ-ийн талаар огт мэдэхгүй байна. Гэхдээ “үйлдвэрлэгч” болон “үйлчилгээ үзүүлэгч” хоёр бүлгийн хооронд мэдэгдэхүйц ялгаа ажиглагдаагүй. Судалгаанд оролцогчдын ихэнх нь ТЭЗ-ийг “хог хаягдлыг ангилах, дахин боловсруулах”-тай холбон ойлгож байна.

Үнэлгээнд ашигласан 11 үзүүлэлтээс санхүү/хөрөнгө, технологи, тоног төхөөрөмж, хөрөнгө (барилга, байгууламж, үл хөдлөх хөрөнгө)-ийн бэлэн байдал хамгийн доод түвшинд байсан бол түншлэл, хамтын ажиллагаа тогтооход бэлэн байдал, нягтлан бодох бүртгэлийн чадавх, тогтвортой байдалд чиглэсэн

бизнесийн соёл хамгийн өндөр үнэлгээ авчээ. Сонирхолтой нь орлогын түвшин, үйл ажиллагаа эрхэлсэн хугацаанаас үл хамааран бизнес эрхлэгчдийн ТЭЗ-ийг нэвтрүүлэх бэлэн байдал ижил түвшинд үнэлэгдсэн. Улаанбаатар хотын бизнес эрхлэгчдийн бэлэн байдал орон нутгийн бизнес эрхлэгчдээс харьцангуй өндөр байна. Судалгаанд хамрагдсан ААН-үүдийн 28% нь хөрөнгийн хувьд бүрэн хүчин чадалтай, 50.5% нь сайжруулах шаардлагатай, 10.8% нь хүчин чадал муутай, 5.3% нь бэлэн биш, харин 4.5% нь бэлэн байдлыг үнэлэх боломжгүй гэсэн ангилалд багтсан.

Аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулдаг олон газрын барилга байгууламж дэд бүтцийн шугамд холбогдоогүйн улмаас эрчим хүчний хангамжийн асуудалтай тулгардаг бөгөөд хагас дэд бүтцийн шийдэл нь ихэвчлэн өндөр өртөгтэй байдаг. Эдгээр нөхцөл байдлаас хамааран байраар хангах үйлчилгээ нөөцийн үр ашигтай байдлыг төдийлөн хангаж чадахгүй байна. Сүүлийн үед “ногоон зээл”-ээр дамжуулан

санхүүгийн дэмжлэгийг нэмэгдүүлсний ачаар аялал жуулчлалын үйлчилгээнд пассив сууц ашиглах хандлага нэмэгдэж байна (Монгол банк, 2021). Пассив сууцыг сурталчлах замаар нөөцийн хэмнэлт гаргаж, дулаан алдагдлыг бууруулж, орон сууцны ашиглалтын хугацааг уртасгах ТЭЗ-ийн стратегийг хэрэгжүүлэх боломжтой юм.

Ерөнхийдөө бэлэн байдлын хувьд, судалгаанд оролцогчдын 28% нь бүрэн хүчин чадалтай, 52.8% нь сайжруулах шаардлагатай, 9.3% нь хүчин чадал муу, 6.5% нь бэлэн биш, 3.5% нь үнэлж

чадаагүй. Бизнес эрхлэгчид нь ТЭЗ-ийн стратеги, шийдлүүдийг авч хэрэгжүүлэхэд ихэвчлэн санхүүгийн бэрхшээлээс шалтгаалан тоног төхөөрөмж дутагдалтай байна. Түүнчлэн, бизнес эрхлэгчдийн цахим шилжилтийн явц удаашралтай байгаа нь тэдний цахим хэрэглээний мэдлэг, ур чадвар хангалтгүйгээс шалтгаалж байна. Энэ үзүүлэлтийн хувьд судалгаанд оролцогчдын 20.8% нь бүрэн хүчин чадалтай, 53.5% нь сайжруулах шаардлагатай, 15.8% нь хүчин чадал муутай, 5% нь огт бэлэн биш бөгөөд 5% нь ТЭЗ-ийг нэвтрүүлэхэд бэлэн эсэхээ үнэлж чадаагүй.

Зураг 4. Бэлэн байдлын үнэлгээний хураангуй



Бүтээгдэхүүн, үйлчилгээний амьдралын мөчлөгийн үе шатууд дахь оролцоо

“Үйлдвэрлэгч бүлэг”-т хамрагдсан бизнес эрхлэгчдийн дийлэнх нь үйлдвэрлэлийн үйл ажиллагааны (68%) болон борлуулалт, маркетингийн (42.3%) үе шатанд оролцож байна. Бүх салбарын хувьд бүтээгдэхүүний загварчлалд нөлөөлөх байдал доогуур (хүнсний үйлдвэрийн оролцогчдын 24.7%, шингэн хүнсний үйлдвэрийн 40%) байна. Шингэн хүнсний үйлдвэрүүд худалдан авалтын шатанд голчлон анхаардаг. Ойролцоогоор 80% нь борлуулалт,

маркетингийн үе шатанд илүү санаа тавьдаг ажээ. Харин хүнсний үйлдвэрүүд худалдан авалт, үйлдвэрлэл, борлуулалт, маркетингийн үе шатанд илүү идэвхтэй оролцдог. Тэд ихэвчлэн нийлүүлэлт талын бизнесийн уламжлалт загварыг (худалдан авалт, үйлдвэрлэл, борлуулалт, маркетингийг багтаасан) баримталдаг.

Дундын хэрэглэгч бүлгийн хувьд бүтээгдэхүүн (үйлчилгээ)-ний амьдралын мөчлөгийн үе шатууд дахь оролцоог үйлчилгээний талаас авч үздэг. Дундын хэрэглэгчдийн ихэнх нь борлуулалт, маркетинг (28.7%)

болон бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээ (26.2%)-нд илүү ач холбогдол өгдөг ба бусад үе шатанд тэдний оролцоо харьцангуй бага. Дундын хэрэглэгчдийг үйл ажиллагааны төрлөөр нь авч үзвэл, үйлчилгээ үзүүлэгч бүлэг нь дизайн, хэрэглээ болон хэрэглээний дараах үе шатанд бараг ижил түвшний оролцоотой байдаг ба 12.5%-25% хооронд хэлбэлзэж байна. Худалдан авалтын шатанд хүнсний дэлгүүрүүдийн оролцоо хамгийн өндөр буюу 44.1%, байраар ханган нийлүүлэгчид үйлдвэрлэлийн шатанд өндөр буюу 58.6% нь оролцож байгаа нь бусад бүлэгтэй харьцуулахад хамгийн өндөр үзүүлэлт юм.

Бизнес эрхлэгчид нар бизнесийн үйл ажиллагаандаа бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийг бүхэлд нь хамруулж чаддаггүй тул үе шат бүрд эдийн засаг, байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийг цогцоор нь (холбогдох үйлчилгээг хамруулан) үнэлэхэд хүндрэлтэй, ялангуяа дизайн болон ашиглалтын дараах үе шатуудад үнэлгээ хийх боломжгүй байна. Үүний улмаас ТЭЗ-ийн зарчимд суурилсан стратеги, шийдлүүдийг нэвтрүүлэх боломж хязгаарлагдаж, улмаар цаашид ТЭЗ-ийг өргөн хүрээнд системтэйгээр хөгжүүлэх хэтийн бодлогод саад болохоор харагдаж байна.

Бүтээгдэхүүнийг дахин загварчлах үе шатны хувьд үйлдвэрлэгчид бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн үе шат бүрд тохирсон ТЭЗ-ийн шийдлүүдийг судалж, хэрэгжүүлэх боломжтой. Хүнсний салбарын бизнес эрхлэгчдийн 24.7% орчим нь бүтээгдэхүүн, үйлчилгээний загвар гаргахад гар бие оролцдог. Харин энэ үзүүлэлт ус ундаа, сав баглаа боодлын салбарын бизнес эрхлэгчдийн хувьд тус тус 40% ба 33.3%. Хөдөө орон нутагт байрлах компаниуд загварчлалын шатанд

харьцангуй илүү буюу үйлдвэрлэгч, үйлчилгээ үзүүлэгч тус бүр 31.9% ба 26.3% байна. Эдгээр тоо нь компаниудын дизайны чадавх, мөн тэдний бүтээгдэхүүнд үйлчлүүлэгчдээс тавих шаардлагын илрэл байж болох юм.

Худалдан авалтын шатанд үйлдвэрлэгчийн бүлэг нь "нийлүүлэлтийг тойрогт оруулах" стратегитай нягт холбоотой ба энэ нь тогтвортой эх үүсвэрээс нөөц, материал, эрчим хүчээ хангах тухай ойлголт юм. Ихэнх тохиолдолд илүү тогтвортой, ТЭЗ-т нийцсэн шийдлүүдийг олохын тулд дизайны үе шатнаас эхлэх ёстой. Нөгөө талаас үйлчилгээ үзүүлэгчид нөөц, материал, эрчим хүчний тогтвортой эх үүсвэрт илүү анхаарал хандуулдаг. Тэд бүтээгдэхүүн худалдан авах, ТЭЗ-т бизнесийн шинэ загвар нэвтрүүлэхдээ ихэвчлэн олон ханган нийлүүлэгчидтэй харилцдаг. ТЭЗ-ийн шийдлүүдийг амжилттай хэрэгжүүлэх эсэх нь зах зээлийн бэлэн байдлаас хамаарна.

Үйлдвэрлэлийн үе шатны хувьд, бизнес эрхлэгчдийн дийлэнх нь буюу 68% нь энэхүү үе шатанд оролцож байна. Ялангуяа хүнсний үйлдвэрийн 72.6%, үйлчилгээ үзүүлэгчид (хоол хүнс үйлдвэрлэл)-ийн 67.4%, сав баглаа боодлын салбарын 66.7% нь үйлдвэрлэлийн үе шатанд оролцдог. Харин ус ундаа үйлдвэрлэдэг компаниудын дөнгөж 20% нь үйлдвэрлэлийн шатанд оролдог аж. Сонирхолтой нь хөдөө орон нутагт (70.2%) бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн үе шатанд оролцдог компанийн эзлэх хувь хотынхоос (67.4%) өндөр байна. Үйлдвэрлэлийн үе шатыг ийнхүү онцолж байгаа нь бизнес эрхлэгчдийн нөөцийн үр ашгийг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Борлуулалт, маркетингийн үе шатанд үйлдвэрлэгчдийн борлуулалт, маркетинг дахь оролцоо нь үйлдвэрлэлийн үе шатны дараа хоёрдугаарт орох ба бизнес эрхлэгчдийн 42.3%-ийг эзэлж байна. Сав баглаа боодол, ус ундаа үйлдвэрлэгчдийн 33.3% нь энэ үе шатанд өндөр (амьдралын мөчлөгийн бусад үе шатуудаас хамгийн өндөр хувьтай) оролцоотой байна. Хот суурин газрын компаниуд хөдөө орон нутгийнхаас 5%-аар илүү борлуулалт, маркетингийн ажилд оролцдог бол олон ажилтантай компаниуд энэ алхмыг илүү нухацтай авч үздэг.

Бүтээгдэхүүний ашиглалт буюу хэрэглээний үе шатанд, үйлдвэрлэгч болон үйлчилгээ үзүүлэгчдийн бүлэг харьцангуй бага оролцоотой.

Хэрэглээний дараах үе шатны хувьд судалгаанд хамрагдсан үйлдвэрлэгчийн бүлэг дэх бизнес эрхлэгчдийн оролцоо мэдэгдэхүйц бага буюу ердөө 20.3% байна. Оролцоо ийнхүү бага байгаа нь тэдний багахан хэсэг нь хоол хүнс, төрөл бүрийн хатуу хог хаягдал бүхий ашиглалтын хугацаа дууссан бүтээгдэхүүнийг савлах, цуглуулах, ангилах, боловсруулах зэрэг хэрэглээний дараах үйл ажиллагаанд идэвхтэй оролцдогтой холбоотой байж болно. Үйлдвэрлэгчдийн дунд сав баглаа боодлын жижиг дунд үйлдвэрүүдийн 16.7% нь энэ үе шатанд оролцоотой байсан бол хүнсний үйлдвэр хамгийн бага оролцоотой буюу 7.9% байна. Бизнес эрхлэгчдийн 9% гаруй нь нийт ажиллагсдын тооноос үл хамааран хэрэглээний дараах үе шаттай холбоотой тодорхой хэмжээний үйл ажиллагаа хэрэгжүүлсэн байна.

Нөөцийн үр ашгийг нэмэгдүүлэх стратегиуд

Бизнес эрхлэгчид хог хаягдалгүй үйл

ажиллагаа явуулах, ялангуяа хуванцар хаягдлыг багасгахад анхаарал хандуулах нь зүйтэй. Түүнчлэн тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацааг уртасгах, нөөцийн хэмнэлт болон цэвэр үйлдвэрлэлийн зарчмыг нэвтрүүлж, түлш, цахилгааны хэрэглээг багасгах эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл ашиглах талаар хүчин чармайлт гаргах хэрэгтэй. Нөөцийн хэмнэлт, цэвэр үйлдвэрлэлийн талаар бүрэн ойлголтой байх нь ухаалаг хэрэглээг сурталчилж буй явдал юм. Энэ нь тоног төхөөрөмж, автомашин үйлдвэрлэгчдийн нөөцийн хэмнэлтийн зарчмуудыг Монгол Улсад нэвтрүүлэх удаан хугацааны оролдлоготой холбоотой байж болох юм. Гэсэн хэдий ч ААН-үүдийн 61.3% нь нөөцийн хэмнэлт, цэвэр үйлдвэрлэлийг тооцох механизм дутмаг байгааг онцлох нь зүйтэй. Энэ нь тухайн салбарууд дахь нөөцийн хэмнэлт, цэвэр бүтээгдэхүүний талаарх мэдлэгийн түвшин болон бодит хэрэгжилтийн хооронд зөрүү байгааг харуулж байна.

Үйлдвэрлэгчид нөөцийн хэмнэлт, цэвэр үйлдвэрлэлийн бодлогыг хэрхэн хэрэгжүүлэх, үүнд хэрхэн системтэй хяналт тавих талаар мэдлэг хангалтгүй байна. Үйлчилгээ үзүүлэгчдийн ойролцоогоор 34.3% нь нөөцийн хэмнэлт, цэвэр үйлдвэрлэлийн үнэлгээг хийсэн ба бараг 58% нь нөөцийн хэмнэлт, цэвэр үйлдвэрлэлийн бодлогыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх эрмэлзэлтэй байна.

Хотын үйлчилгээ үзүүлэгчид хөдөө орон нутгийнхтай харьцуулахад нөөцийн хэмнэлттэй холбоотой илүү олон хариултыг сонгожээ. Түүнчлэн олон ажилтантай том компаниуд цөөн тооны ажилтантай компаниудтай харьцуулахад нөөцийн хэмнэлтийг илүү өргөн хүрээнд хэрэгжүүлдэг аж.

Бүтээгдэхүүний ашиглалтын хугацааг уртасгах стратегиуд

Нөөцийг хэмнэх эдгээр стратеги нь сав баглаа боодлын салбарт илүү тохиромжтой бөгөөд хоол хүнс, ус ундааны сав баглаа боодолд ашиглах боломжтой. Бүтээгдэхүүний сав баглаа, боодлыг цуглуулах оролдлого нь логистик болон хэрэглэгчийн зан үйлтэй холбоотой сорилтуудтай тулгардаг ба зөвхөн цөөн тооны байнгын хэрэглэгчид бүтээгдэхүүнийхээ савыг буцаан тушаадаг аж. Үйлдвэрлэгчдийн хувьд, засвар хийх замаар тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацааг уртасгадаг. Тус бүлэг тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацааг засаж сэлбэх (асуулгад оролцогчдын 83.8%), урсгал засвар үйлчилгээ хийх зэргээр уртасгаж, илүү сайн чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Үйлчилгээ үзүүлэгчдийн хувьд хэрэглэж буй тоног төхөөрөмж, тавилга, савласан бүтээгдэхүүнийг урт хугацаанд ашиглах замаар бүтээгдэхүүний насжилтыг уртасгахад дэмжлэг үзүүлдэг. Тэд үйлчлүүлэгчдэд бүтээгдэхүүний савлагааг дахин ашиглахыг санал болгодог (санал асуулгад оролцогчдын 59.6%) ч ердөө 21.3% нь сав баглаа боодлыг дахин ашиглах, дахин боловсруулах үйл явцад оролцдог байна.

Үйлчилгээнд суурилсан загварт шилжих стратегиуд

ТЭЗ нь бүтээгдэхүүн борлуулахаас илүүтэй үйлчилгээг чухалчилсан загвар руу шилжих замаар уламжлалт бизнесийн арга барилд өөрчлөлт авчрахыг зорьдог. ТЭЗ-ийн бизнесийн шинэ загваруудыг нэвтрүүлээд хөрөнгө болон тоног төхөөрөмжөө хуваалцах, үйлчилгээнд суурилсан бүтээгдэхүүн санал болгох, хог хаягдал цуглуулах болон дахин боловсруулах зэрэг шинэ сорилтуудтай тулгарах нь тодорхой. Судалгаанд хамрагдсан бизнес

эрхлэгчдийн 25.2% нь тоног төхөөрөмжөө хуваалцдаг гэдгээ илэрхийлсэн ба энэ нь тэдний үйлчилгээнд суурилсан үйл ажиллагаа эрхэлдэгтэй холбоотой байж болох юм. Судалгаанд оролцогчид "бүтээгдэхүүн-үйлчилгээ"-ний ойлголтыг хангалттай сайн мэдэхгүй байх талтай.

Хаягдлын дараах нөхөн сэргээлтийн стратегиуд

Судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчдийн ТЭЗ-ийн талаарх ойлголт нь голчлон хог хаягдлын менежментэд төвлөрч байна. Үйлдвэрлэл эрхэлдэг бизнес эрхлэгчдийн 50% нь хог хаягдлыг цуглуулах, ангилах зэргээр хог хаягдлын менежментийн системийг нэвтрүүлсэн бол ердөө 22.5% нь хог хаягдлын дахин боловсруулалтыг дэмжих тогтолцоог бүрдүүлж, 35.6% орчим нь хог хаягдлын менежментийн чиглэлээр ажилчдадаа сургалт хийдэг. Судалгаанаас харахад хот суурин газрын компаниуд хөдөө орон нутгаас илүү олон хог хаягдлын дараах нөхөн сэргээлтийн арга хэмжээг сонгосон байна.

Нийлүүлэлтийг тойрогт оруулах стратегиуд

Ерөнхийдөө судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчдийн нийлүүлэлтийн эх үүсвэрийн талаарх ойлголт дунд зэрэг ба тэд илүү тогтвортой орц материал, байгальд ээлтэй эрчим хүчний эх үүсвэр ашиглахад бэлэн байна. Тэдний ашигладаг сав баглаа боодлын материалаас нийлэг уут хамгийн түгээмэл буюу 76.1%-ийг эзэлдэг. Мөн дахин боловсруулсан цаас, хуванцар, шил, цаасан уут зэргийг ашигладаг. Судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчдийн 8.6% орчим нь байгалийн гаралтай материалыг савлагаанд ашигладаг. Бизнес эрхлэгчдийн багахан хувь (4.1%) нь нарны эрчим хүчийг ашиглаж байна.

Тойрог бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлтийг дэмжих стратегиуд

Үйлдвэрлэгч бүлэгт хамаарах бизнес эрхлэгчдийн 87.4% нь дахин боловсруулалтыг дэмжих зорилгоор хог хаягдлыг ангилдаг бол үйлчилгээ үзүүлэгч бүлгийн 84.8% нь хог хаягдал ангилахыг чухалчилдаг. Түүнчлэн үйлдвэрлэгчдийн 86.9% нь ханган нийлүүлэгчдээсээ

тогтвортой байдлын талаар мэдээлэл авахыг хүсдэг бол 60.4% нь энэ мэдээллийг түншүүд болон үйлчлүүлэгчидтэйгээ тогтмол хуваалцдаг байна. Харин үйлчилгээ үзүүлэгчдийн 83.7% нь ханган нийлүүлэгчдээсээ ихэвчлэн бүтээгдэхүүний тогтвортой байдлын талаарх мэдээллийг хүсдэг аж.

Б. ЭРЭЛТ БУЮУ ХЭРЭГЛЭГЧ ТАЛ

Аялагчид байрласан газрынхаа байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулахын тулд сайжруулах шаардлагатай зүйлсийг дараах байдлаар илэрхийлжээ. Тухайлбал, 63% нь дахин ашиглаж болох хог хаягдлыг ялгаж дахин боловсруулах цэгт өгөх, 36% нь бохироо гол усанд болон ил задгай хаяггүйгээр соруулж зохих цэвэрлэгээний байгууламжид өгдөг байх, 32% нь амрагч жуулчдад байгальтай зохистой харьцах сануулга, мэдээллийн самбар байршуулах арга хэмжээнүүдийг онцолжээ.

Нөөцийн үр ашгийг нэмэгдүүлэх стратегиуд

Судалгаанд оролцогчид нөөцийн үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг чухалчилдаг ба тэдний 93% нь байгалийн нөөцийг үр ашигтай ашиглах, хог хаягдлыг бууруулах, ус, цахилгаан эрчим хүчний тогтвортой үйлдвэрлэл зэрэг арга хэмжээг дэмжиж байна. Мөн тэдний 88% нь “тэг хаягдал”-ын бодлого, ялангуяа хуванцар хог хаягдлыг хэрхэн бууруулах талаар мэддэг, 82% нь түлш, цахилгааны хэмнэлттэй тээврийн хэрэгслийг чухалчилдаг бол 66% нь байгалийн нөөцийн үр ашгийг дээшлүүлэх, хог хаягдлыг бууруулах, ус, цахилгаан эрчим хүчний хэмнэлттэй үйлдвэрлэлийг дэмжих санаачилгыг дэмжиж байна.

Бүтээгдэхүүний ашиглалтын хугацааг уртасгах стратегиуд

Судалгаанд оролцогчдын 90% нь сав, баглаа боодлын материалыг дахин ашигладаг гэж хариулсан нь анхаарал татаж байна. Мөн үйлдвэрлэгчдийн 83% нь бүтээгдэхүүнийхээ бат бөх чанарыг сайжруулах оролдлого хийж, 79% нь хэрэглэгчдэдээ сав баглаа, боодлыг үндсэн болон өөр зориулалтаар дахин ашиглахыг уриалж, дахин ашиглалтад онцгой ач холбогдол өгч байна.

Үйлчилгээнд суурилсан загварт шилжих стратегиуд

Энэ стратеги нь нийлүүлэлт талд илүү хамааралтай учир судалгаанд оролцогч энэ талаар сайн ойлголтгүй байсныг тэмдэглэх нь зүйтэй.

Хаягдлын дараа нөхөн сэргээх стратегиуд

Аялагчдын худалдан авалтад байгальд ээлтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ хэрхэн нөлөөлдгийг тодруулахад 86% нь хог хаягдлыг дахин боловсруулах тогтолцоотой эсэхийг харгалзан үзнэ гэлээ. Үүний адилаар, 85% нь хог хаягдлыг ангилан ялгах тогтолцоотой эсэх, 81% нь өөрсдийн бүтээгдэхүүний савыг буцааж авдаг эсэх, 79% нь хог хаягдлыг цуглуулах менежментийн

системтэй эсэхийг харгалзан үздэг. Үүнээс аялагчид хог хаягдлыг сэргээн ашиглах менежментийн тогтолцоог сонирхож буй нь харагдлаа. Гэвч үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудаас хог хаягдлыг ангилан ялгах менежментийн тогтолцоо дутмаг байна.

Нийлүүлэлтийг тойрогт оруулах стратегиуд

Аялагчдаас шингэн хүнс худалдан авахдаа бүтээгдэхүүний савлагааны материалыг харгалзан үздэг эсэхийг тодруулахад 85% нь бүтээгдэхүүний орц, найрлага, аюулгүй байдлыг харгалзан худалдан авалт хийдэг аж. Харин судалгаанд оролцогчдын 76% дахин ашиглах, боловсруулах боломжтой сав баглаа боодлыг илүүд үзэж байна.

Тойрог бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлтийг дэмжих стратегиуд

Аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэгчид болон хүнс үйлдвэрлэгчдийн байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүнийг эцсийн хэрэглэгчид өндрөөр үнэлдэг. Гэвч аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа эрхлэгчдийн хувьд хог хаягдлыг ангилан ялгах, буцаан авах, дахин боловсруулах үйл ажиллагаа хангалтгүй байна. Судалгаанаас харахад, аялагчдын 77% нь өөрөө хогийн уут авч явж, 70% нь хог хаягдлаа хамгийн ойр байрлах зориулалтын цэгт аваачдаг бол, 34% нь хогийн саванд хаядаг байна.

Аялагчдын 98% нь аялал жуулчлалын салбарт хог хаягдалгүй, байгальд ээлтэй үйлдвэрлэл, үйлчилгээг хүсэмжилж байна. Хэдийгээр хэрэглэгчид нь тогтвортой байдлыг чухалчилж байгаа ч үйлчилгээ үзүүлэгчид, үйлдвэрлэгчдийн хувьд энэ хэрэгцээ шаардлагыг хангахад бэлэн биш байна. Мөн аялагчдын 91% нь байрлах газраа сонгоход байгальд ээлтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ санал болгож буй

эсэх нь дунд зэрэг болон ихээр нөлөөлнө гэсэн бол үлдсэн 9% нь энэ шалгуур тэдний сонголтод төдийлөн нөлөө үзүүлэхгүй гэжээ.

Аялагчдын дийлэнх нь (73%) байгальд ээлтэй бүтээгдэхүүн, үйлчилгээнд илүү өндөр төлбөр төлөх бүрэн боломжтой гэжээ. Гэвч тэдний 45% нь байгальд ээлтэй бизнесийг олж үйлчлүүлэхэд хүндрэлтэй гэсэн бол 44% нь бага зэрэг хүндрэлтэй гэсэн нь өнөөгийн зах зээлд нийлүүлэлт талаасаа цөөн тооны байгальд ээлтэй үйлдвэрлэл, үйлчилгээ явуулдаг бизнес байгааг илтгэж байна.


Аялал, жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулж буй бизнес эрхлэгчдийн 46% нь ногоон технологи ашиглаж байгальд ээлтэй, хаягдалгүй эдийн засгийн загварт шилжсэнээр нийгмийн хариуцлага нэмэгдэж, бусдад үлгэр дуурайлал болно гэсэн бол, 34% нь ажлын байр нэмэгдэнэ, 28% нь борлуулалтын орлого нэмэгдэнэ, 27% нь хэрэглэгчдийн тоо нэмэгдэнэ, 23% нь бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, үзэмж сайжирна гэж үзжээ.

Хүснэгт 1. ТЭЗ-ийн үндсэн стратегийн дагуу судалгааны гол үр дүнгийн хураангуй

ТОЙРОГ ЭДИЙН ЗАСГИЙН ЗАГВАРЫГ НЭВТРҮҮЛЭХ ҮНДСЭН СТРАТЕГИУД		
1. Нөөцийн үр ашгийг нэмэгдүүлэх стратеги: (10) • Үйлдвэрлэгчдийн 61.3% нь нөөцийн хэмнэлт болон цэвэр үйлдвэрлэлийн хэмжээг тооцох механизм байхгүй • Энэ нь салбаруудын нөөцийн хэмнэлттэй цэвэр үйлдвэрлэл (RECP)-ийн талаарх мэдлэгийн түвшин болон бодит хэрэгжилтийн хооронд зөрүү байна • Байр сууцны үйлчилгээ үзүүлэгчид илүү олон сонголттой, боломжууд байна • Ажилчдын тоогоор нь авч үзвэл томоохон үйлдвэрүүд нөөцийн хэмнэлттэй цэвэр үйлдвэрлэл хийх чадвар өндөр • Хот суурийн газрын үйлчилгээ үзүүлэгчдийн хувьд нь хөдөө орон нутгийнхантай харьцуулахад нөөцийн хэмнэлтийн (RE) сонголт олонтой	3. Үйлчилгээнд суурилсан загвар руу шилжих стратеги: (3) • 25.2% нь тоног төхөөрөмжөө бусадтай хуваалцдаг • Үйлдвэрлэгчид бүтээгдэхүүнээ өөрсдийн тээврийн хэрэгслээр хүргэхээс илүүтэйгээр онлайн дэлгүүр, хүргэлтийн үйлчилгээг ашиглан түгээх	5. Нийлүүлэлтийг тойрогт оруулах стратеги: (14) • Тойрог нийлүүлэлтийн сүлжээнд шилжих нь зөвхөн түүхий эд, нөөцөөр зогсохгүй эрчим хүчний асуудлыг мөн хамардаг • Судалгаанд оролцогчдын хувьд байгаль орчинд ээлтэй, ногоон эсвэл хаягдалгүй нөөц (материал, бүтээгдэхүүн, үйлчилгээ) эсвэл органик хүнсийг (санал асуулгад оролцогчдын 91%-иас дээш) илүүд үзэж байна. • Үйлдвэрлэгчдийн хувьд гялгар уутыг сав баглаа боодлын материалын хувьд ихэвчлэн (76.1%) ашигладаг. • Бизнес эрхлэгчдийн 8.6% орчим нь байгалийн гаралтай материалыг сав баглаа боодлын материал болгон ашигладаг. • Эрчим хүчний хэрэглээний хувьд нүүрснээс гаргаж авсан цахилгаан нь эрчим хүчний гол эх үүсвэр болдог.
2. Бүтээгдэхүүний ашиглалтын хугацааг уртасгах стратеги: (3) • Бизнес эрхлэгчдийн судалгаанд оролцогчдын 50% орчим нь ТЭЗ-ийн стратеги руу чиглэж, бүтээгдэхүүнийхээ аишналтын хугацааг уртасгахыг хичээж байна. Гэвч оролцогч бизнес эрхлэгчдийн 80.2% нь сав багалаа боодлын материалыг дахин боловсруулж, дахин ашиглахад бэрхшээлтэй хэвээр байна. • Үйлдвэрлэгчид бүтээгдэхүүний сав баглаа боодлыг цуглуулах хүчин чармайлт гаргаж байгаа ч бизнес эрхлэгчдэд логиستيкийн хязгаарлалт, хэрэглэгчийн зан төлөвийн хүчин зүйлээс шалтгаалан бэрхшээлтэй тулгардаг • Сав баглаа боодлын салбар нь бүтээгдэхүүний ашиглалтын хугацааг уртасгах хамгийн өндөр боломжтой салбар юм. • Хамгийн түгээмэл арга нь тоног төхөөрөмжийг засварлах бөгөөд үүнийг 83.8% нь сонгожээ	4. Хаягдлын дараах нөхөн сэргээлтийн стратеги: (5) • Бизнес эрхлэгчдийн ТЭЗ-ийн талаарх ойлголт нь хог хаягдлын менежментэд голчлон төвлөрдөг. • Бизнес эрхлэгчдийн 50% нь хог хаягдлыг цуглуулах, ангилах зэрэг үйл ажиллагааг хамарсан хог хаягдлын менежментийн системийг нэвтрүүлсэн. • 22.5% нь хог хаягдлын дахин боловсруулалтыг дэмжих тогтолцоог бүрдүүлсэн бөгөөд. • 35.6% орчим нь хог хаягдлын менежментийн чиглэлээр ажилладаг сургалт явуулдаг байна. • 92.3% орчим нь хог хаягдлаа хогийн цэгт булдаг	6. Тойрог бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлтийг дэмжих стратеги: (4) • Бизнес эрхлэгчдийн 87.4% хог хаягдлаа ангилан ялгадаг бол • 86.9% нь ханган нийлүүлэгчдээс бүтээгдэхүүнийхээ тогтвортой байдлын талаар мэдээлэл авахыг хүсдэг • 60.4% нь уг мэдээллээр түнш, үйлчлүүлэгчдтэйгээ тогтмол харилцдаг байна. • Тэдний дөнгөж 32.9% нь дахин боловсруулах боломжтой бүтээгдэхүүнээ эргүүлэн авах талаар тодохой үйл ажиллагаа явуулдаг.



ТОЙРОГ ЭДИЙН ЗАСАГ ГЭЖ ЮУ ВЭ?



**ТАВ. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН
ҮНЭЛГЭЭ**

ТАВ. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ҮНЭЛГЭЭ

Оролцогч талуудын үнэлгээгээр аялал жуулчлалын салбарт ТЭЗ-ийг хөгжүүлэхэд оролцогч талуудын үүрэг оролцооны ерөнхий зураглалыг гаргалаа. Олон төрлийн оролцогч талууд Монголын аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж, салбарын удирдлага, өсөлт, тогтвортой байдалд хувь нэмрээ оруулдаг тул тэдгээрийн хамтын ажиллагаа, уялдаа холбоо нь тус салбарт ТЭЗ-ийг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой. Аялал жуулчлалын салбарт нөөцийн үр ашгийг дээшлүүлэх, тогтвортой байдлын загварыг төлөвшүүлэхэд одоогийн хүчин чармайлт, санаачилгууд хэр нийцэж байгааг үнэлэх үүднээс дийлэнх шинжилгээ нь бизнес эрхлэгчдийн үзэл бодолд тулгуурласан.

Уг үнэлгээгээр ТЭЗ-ийн арга барилыг нэвтрүүлснээр хамгийн их ашиг хүртэх аялал жуулчлалын салбарын эмэгтэй удирдлагатай бизнес эрхлэгчдээс эхлээд салбарын зорилтуудад чухал нөлөө үзүүлэхгүй талуудыг ч мөн тодорхойлсон. Энэ хүрээнд 10 төрлийн оролцогч талын бүлгийг олж тодорхойлон, дараах байдлаар


4 ангилсан. Үүнд, (1) техникийн зуучлагч (зөвлөх үйлчилгээ ба гэрчилгээжүүлэлтийн байгууллага, шинжлэх ухааны байгууллага, технологийн ханган нийлүүлэгчид), (2) санхүүгийн байгууллагууд (олон улсын болон дотоодын), (3) хөгжлийн байгууллагууд (төрийн болон олон улсын), (4) салбарын зуучлагчид (холбоо, томоохон ААН, ТББ).

Бизнес эрхлэгчдийн тухайд нэн чухал асуудлыг тусгасан оролцогч талуудын үнэн зөв цогц зураглал гаргахын тулд төслийн зорилтуудтай уялдуулсан онооны шалгуурыг гаргалаа. Оролцогч талуудын зураглалд өөр өөр шалгуурыг ашигладаг бөгөөд уг төслөөр сонгосон хамгийн тохиромжтой шалгуурууд нь: I. Хамтран ажиллах ашиг сонирхол буюу хүсэл эрмэлзэл, II. Туршлага, III. Нөлөө/эрх мэдэл, IV. ТЭЗ-ийн хэрэгжилтэд оролцох (зарим оролцогч талын) чадавх, нөөц зэрэг байв. Сонгосон шалгуурын дагуу оролцогч талуудыг оноогоор үнэлэх асуултуудыг харууллаа (**Хүснэгт 2**).

Хүснэгт 2. Оролцогч талуудыг оноогоор үнэлэх шалгуур

ШАЛГУУР	ЧИГЛҮҮЛЭХ АСУУЛТУУД
Ашиг сонирхол	Аялал жуулчлал дахь хоол хүнс, ус ундааны үйлдвэр, сав баглаа боодлын салбарт ТЭЗ-ийн арга барилыг нэвтрүүлэхтэй холбоотой оролцогч талуудын ашиг сонирхол юу вэ? Уг оролцогч тал нь ТЭЗ-ийн арга барилаас шууд ашиг хүртэх үү?
Туршлага	ТЭЗ-ийн арга барилыг нэвтрүүлэхэд ямар нэгэн дэмжлэг үзүүлэх, хэрэгжүүлэх, болон бусад үйл явцад оролцогч тал хэр туршлагатай вэ?
Нөлөө / эрх мэдэл	Тухайн оролцогч тал бизнес эрхлэгчдэд ТЭЗ-ийн арга барилыг нэвтрүүлэхэд нөлөөлөх үү?
Чадавх, нөөц	Оролцогч тал нь бизнес эрхлэгчдэд ТЭЗ-ийн арга барилыг хөгжүүлэх явцад оролцох чадавхтай юу? Үүнд оролцоход ямар нөөц ашиглах боломжтой вэ?
Нийт оноо	Дээрх дөрвөн үнэлгээний дундаж

Зураг 5. Монгол Улсын аялал жуулчлалын салбарын оролцогч талуудын зураглал



Төрийн байгууллагуудын ТЭЗ-ийг нэвтрүүлэх сонирхол дундаж түвшинд байна. Тухайлбал, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, орон нутгийн засаг дарга нар, Нийслэлийн аялал жуулчлалын газар бусад төрийн байгууллагаас өндөр оноо өгчээ. Бусад үндэсний түвшний оролцогч талуудын хувьд, эдийн засаг, экологи, нийгмийн тогтвортой байдлын стратегийг өргөн утгаар нь авч үздэг, богино хугацаанд аудит, мониторингд тусгасан гэдэг утгаараа ашиг сонирхол нь харьцангуй бага байв. ТЭЗ-тэй холбоотой хууль тогтоомж, зохицуулалтын механизмыг тогтвортой хөгжилд чухал ач холбогдолтой гэж тодорхойлсон.

Олон улсын байгууллагуудыг бусад оролцогч талтай харьцуулахад ТЭЗ-ийн арга барилыг нэвтрүүлэхэд хамгийн өндөр ашиг сонирхолтой бөгөөд тэдний ТЭЗ-

ийг дэмжин ажиллах сонирхол нь эдийн засаг, экологи, нийгмийн хувьд тогтвортой хөгжлийг бий болгох зорилготой нь шууд холбогдож байна. Салбарын байгууллагууд, ялангуяа ТББ-ын бүлгүүд ТЭЗ-ийг бизнесийн бодлогод тогтвортой байдлын зарчмыг нэвтрүүлэх, цогц бөгөөд тогтвортой үнэ цэнийг бий болгоход туслах хэрэгсэл гэж үздэг. Холбоод болон томоохон ААН-ийн хувьд аялал жуулчлалын салбарын бизнес эрхлэгчдэд ТЭЗ-ийг нэвтрүүлэх сонирхол дунд зэрэг байгаа ч МҮХАҮТ ногоон зочид буудлын гэрчилгээ, органик гэрчилгээжүүлэлт олгодог гэдэг утгаараа холбоодоос хамгийн өндөр оноо авчээ.

Санхүүгийн байгууллагууд, ялангуяа олон улсын санхүүгийн байгууллагуудын дунд ТЭЗ болон тогтвортой байдлыг дэмжих сонирхол өндөр байна. Санхүүгийн

байгууллагууд нь ТЭЗ-ийн туршлагад хөрөнгө оруулалт хийх боломжоор хангах, ТЭЗ-ийг нэвтрүүлэх чадавхыг нэмэгдүүлэхийн тулд томоохон бизнесүүд болон нийлүүлэлтийн сүлжээний түншүүдтэй хамтран ажиллах зэргээр бизнес эрхлэгчдэд туслах боломжтой. Мөн нийлүүлэлтийн сүлжээг тогтвортой хөгжүүлэхэд хувь нэмэр оруулж чадна.

ТЭЗ-ийн стратегийг хэрэгжүүлэх туршлагын хувьд, үндэсний хэмжээнд, төрийн байгууллагуудын аялал жуулчлалын салбарт ТЭЗ-ийг дэмжсэн бодлого, зохицуулалт байгаа ч тухайн байгууллагын чиг үүрэгт шууд хамааралгүй тул ТЭЗ-ийн хэрэгжилтийг хангах туршлага бусад оролцогч талуудаас харьцангуй доогуур байна. Олон улсын санхүүгийн болон хөгжлийн байгууллагууд аялал жуулчлал болон бусад салбарын ТЭЗ-т чиглэсэн олон төрлийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлдэг тул хамгийн их туршлагатай бөгөөд ТЭЗ-ийг тогтвортой хөгжлийг дэмжих, экологийн асуудлыг шийдвэрлэх боломж гэж үзэж байна.

Томоохон ААН-үүд ТЭЗ-ийг өөрсдийн дүр төрх, өрсөлдөх чадвараа сайжруулах, сайн сайхан байдлыг бий болгох, ирээдүйн үнэ цэнийг нэмэгдүүлэх, чадварлаг ажилчдыг татах чухал арга хэрэгсэл гэж үздэг. Компаниудын туршлага нь голчлон эдийн засаг, бизнесийн асуудлуудад төвлөрсөн байв. Техникийн ханган нийлүүлэгч талууд байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх мэдлэг туршлагаа хуваалцахад бэлэн байдаг.

Эрдэм шинжилгээний байгууллагууд энэ талаарх туршлага хамгийн доогуур гэж тодорхойлогдсон нь ТЭЗ-ийн загварт чиглэсэн зохих ёсны сургалтын хөтөлбөр байхгүй, мөн мэдлэг туршлага хуваалцах

үйл ажиллагаа хангалтгүй байгаатай холбоотой. Ерөнхийдөө, энэ сэдвээр мэргэжилтэн бэлтгэх, сургалт явуулах, судалгааны ажил одоогоор хангалтгүй байна.

ТЭЗ-ийн туршлагыг нэвтрүүлэхэд бизнес эрхлэгчдийн нөлөө оролцогч талуудын бүлэг тус бүрээр харилцан адилгүй байна. Төрийн байгууллагууд бизнес эрхлэгчдэд ТЭЗ-ийн зарчимд шилжихэд нь туслах бодлого, хөтөлбөрүүдийг бий болгох, санхүүгийн урамшуулал, буцалтгүй тусламж, татаас олгохыг дэмжиж байна. Гэхдээ дээрх механизмууд нь улсын хэмжээнд нэгдмэл бодлого, төлөвлөгөөний хүрээнд бус, Засгийн газрын төрөл бүрийн чиг үүргүүдэд хуваагдсан байдаг.

ТББ, салбарын холбоод, ялангуяа аялал жуулчлалын салбар дахь бизнес эрхлэгчид ТЭЗ-ийн стратегийг хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон бизнес эрхлэгчид эдгээр байгууллагад сайн дурын үндсэн дээр элссэн байдаг тул тэднийг салбар дотроо ТЭЗ-ийг дэлгэрүүлэх гол түншүүд гэж үзэж болно.

Үнэлгээний үр дүнд оролцогч талуудыг ашиг сонирхол, туршлага, нөлөөллөөр нь харилцаа, хамтын ажиллагааны стратегид үндэслэн дараах 4 бүлэгт хуваасан. Үүнд, (1) төрийн байгууллага болон холбоодыг багтаасан **“Сэтгэл ханамжтай байлгах”** бүлэг, (2) зөвлөх үйлчилгээ, гэрчилгээжүүлэлтийн байгууллага, олон улсын санхүүгийн байгууллага, ТББ-зэрэг багтсан **“Нягт уялдаатай ажиллах”** бүлэг, (3) технологийн ханган нийлүүлэгч болон олон улсын хөгжлийн байгууллагуудыг багтаасан **“Мэдээллээр хангах”** бүлэг, (4) эрдэм шинжилгээний байгууллага,


томоохон ААН болон дотоодын санхүүгийн байгууллагуудыг багтаасан “Хяналт тавих” бүлэг.

Аялал жуулчлалын салбарын ТЭЗ-т шилжих үйл явцыг дэмжих хүчин зүйлсийг судлахад оролцогч талуудын дунд сайжруулах шаардлагатай хэд хэдэн зүйл байгааг олж тодорхойлов. Тухайлбал,

төрийн байгууллагууд ТЭЗ-ийн зарчмуудыг үндэсний бодлого, стратегидаа илүү сайн тусгаж, төрийн албан хаагчдын ТЭЗ-ийн үр дүнтэй бодлого боловсруулах, хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлэхэд анхаарах нь зүйтэй. Мөн хүртээмжтэй, оролцоотой хандлагыг хэрэгжүүлэх, бодлого боловсруулах үйл явцад оролцогч талуудыг татан оролцуулах нь нэн чухал.

Хүснэгт 3. Оролцогч талуудын шинжилгээний дүгнэлт

Оролцогч талууд	Ашиг сонирхол	Туршлага	Нөлөөлөл
Техникийн зуучлагчид			
Зөвлөх үйлчилгээ, гэрчилгээжүүлэлт	2.25	1.83	2.16
Эрдэм үйлчилгээ, гэрчилгээжүүлэлт	1	0.5	0.5
Технологийн ханган нийлүүлэгч	2.21	1.71	1.28
Санхүүгийн байгууллагууд			
ОУСБ	2.8	2.5	2.4
ДСБ	1.94	1.93	1.94
Хөгжлийн байгууллагууд			
Олон улсын хөгжлийн байгууллага	2.35	2	1.86
Төрийн байгууллага	1.75	1.21	2.4
Салбарын зуучлагчид			
Холбоо	1.75	1.25	2.16
Томоохон ААН	1.83	2.16	1.83
ТББ	2.6	1.8	2.4





ЗУРГАА. ДҮГНЭЛТ

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Ерөнхийдөө зорилтот салбарууд дахь бизнес эрхлэгчдийн байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулах, ТЭЗ-ийн ахиц дэвшлийг хэмжих туршлага дутмаг байна. Гэхдээ эдгээр салбарын олон бизнес эрхлэгчид эдийн засаг, байгаль орчинд ээлтэй түүхий эд сонгохыг чухалчилдаг. Дотоод урсгал засвар, цэвэрлэгээний туршлага сайн суусан ч байгаль орчинд үзүүлэхнөлөөллийг бууруулах, бүтээгдэхүүн (дахин) зохион бүтээх, дахин ашиглах технологийн боломж хязгаарлагдмал хэвээр байна. Бизнес эрхлэгчид жуулчдын

хэрэгцээ шаардлагыг хангахуйц ТЭЗ-ийн боломжуудаас нэвтрүүлэхэд дараах сорилтуудтай тулгарсаар байна. Үүнд, санхүүгийн эх үүсвэр болон дэмжлэг авах боломж хомс, дэлхийн, бүс нутгийн болон үндэсний ТЭЗ-ийн чиг хандлага хийгээд байгаль орчинд ээлтэй технологийн сүүлийн үеийн дэвшлийн талаарх мэдээлэл хязгаарлагдмал, техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, стратеги шийдлүүд байхгүй, ТЭЗ-д хамаарах стратеги, шийдлүүдийн талаарх мэдээлэл хангалтгүй.

БОДЛОГЫН ҮНЭЛГЭЭ

Монгол улсын хөгжлийн бодлого, үндсэн чиглэл, засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр зорилт зэрэг баримт бичгүүдийг харахад ногоон хөгжил, ТЭЗ-ыг дэмжсэн зорилт, үйл ажиллагаа хэрэгжүүлэх арга хэмжээ төлөвлөгөө харьцангуй сайн тусгагдсан байна. Үүнд, ногоон хөгжлийг дэмжих тухай тусдаа бүлэг болгон оруулсан бөгөөд ингэхдээ цаг уурын өөрчлөлт, ус, хог хаягдал, ногоон худалдан авалт, ногоон технологи гэх мэт салбар дундын асуудлуудыг онцгойлон оруулжээ. Мөн, "Алсын хараа 2050" хөгжлийн бодлогын баримт бичгийн богино дунд хугацааны ТЭЗ-тэй уялдсан зорилт, үйл ажиллагаа нь Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт сайн туссан харагдаж байна.

Зорилтот салбаруудын хүрээнд одоогоор мөрдөгдөж буй бодлогын зорилт, тэдгээрийн зохицуулалтын орчинд ТЭЗ-ыг дэмжиж буй бодлогын хэрэгслийн тухайд салбар дундын 2, аялал жуулчлалын салбарт 2, хүнсний салбарт 2, сав баглаа боодлын салбарт 1, хог хаягдлын салбарт 2 буюу нийт 7 хэрэгсэл үйлчилж байна.

Хэдийгээр сүүлийн үеийн хууль тогтоомжид ТЭЗ-ийн талаар шууд тусгаагүй ч ТЭЗ-ийн зарим ойлголтыг авч үзсэн ба ТЭЗ-ийг дэмжих арга хэрэгслүүдийг Засгийн газраас санаачилж хэрэгжүүлсэн. Тухайлбал, байгаль орчинд ээлтэй дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн хувь хүн, ААН, байгууллагыг эко шошго, ногоон гэрчилгээгээр урамшуулах, татвараас чөлөөлөх, Ногоон зээлийн сан, хөдөө аж ахуйн зохистой технологиор үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг баталгаажуулах ногоон шошго олгох, байгалийн нөөцийг үр ашигтай ашиглах байгаль орчинд ээлтэй техник, тоног төхөөрөмжийн жагсаалт гаргах, байгаль орчны бохирдол, хог хаягдлыг бууруулах зэрэг эрхзүйн зохицуулалт хэдийн бий болсон.

Гэсэн ч ТЭЗ-ийн туршлагыг дэвшилтэт байдлаар (ногоон үйлдвэрлэл, хог хаягдлын менежмент гэх мэт) нэвтрүүлэхэд урамшуулал олгох, дэмжих бодлого одоогоор дутмаг байна. Тогтвортой, ногоон худалдан авалттай холбоотой тодорхой зорилтууд, үйл ажиллагааны стратеги, арга хэмжээнүүд, тухайлбал

ногоон худалдан авалтыг 20%-д хүргэх зорилтыг хэмжих шалгуур үзүүлэлт хэрэгжиж эхлээгүй, мэдээ тайлан нээлттэй бус, сонгогдсон бүтээгдэхүүний ногоон шалгуурыг бий болгох, хүнсний салбарт ногоон эдийн засгийг хөгжүүлэх бодлого хангалтгүй хэвээр байна. ЖДҮ болон ТЭЗ-ийн нэгдсэн бодлого гаргаж, ТЭЗ-ийг дэмжсэн заалтууд, тавигдах шаардлагыг бизнес эрхлэгчдийг дэмжих бодлогод тусгах шаардлагатай.

Түүнчлэн хүнс, сав баглаа боодлын салбарын үйл ажиллагаа, шилдэг туршлага, гэрчилгээжүүлэлтийг ТЭЗ-ийн зарчимд нийцүүлэх хүрээнд тогтсон тодорхойлолт, чиглэл байхгүй байна. Ийнхүү бусад урамшууллын механизмтай уялдаа холбоо сул байгаа нь эдийн засгийн хөгжлийг дэмжих бодлогын үр нөлөөг сулруулж болзошгүй байна. Зочлох үйлчилгээ, хүнсний дэлгүүрийн бизнесүүд байгаль орчинд ээлтэй худалдан авалт хийх (“Хөдөө аж ахуйн зохистой дадал” (GAP) шошготой, органик бүтээгдэхүүн гэх мэт), сав баглаа боодлын хог хаягдлыг багасгах чиглэлээр туршлага багатай байна.

Байгалийн нөөцийг хамгаалах, үүсэх бохирдол хог хаягдлаас урьдчилан сэргийлэх, бууруулахад чиглэсэн эдийн засгийн бодлогын хэрэгслүүд дутмаг байна. Хог хаягдлын менежментийн

зорилт, төлөвлөсөн үйл ажиллагаанууд ихэвчлэн хог хаягдлыг бууруулах болон хаягдлын дараа авах арга хэмжээнд төвлөрсөн байдаг нь нэг дутагдалтай тал юм. ТЭЗ-ийг цогцоор нь хэрэгжүүлэхэд нөөцийг хаягдал болохоос нь өмнө эргэлтэд оруулах, бүтээгдэхүүний насжилтыг уртасгах, байгальд ээлтэй шинэ төрлийн бүтээгдэхүүнийг дэмжих, хог хаягдлыг дахин ашиглахад дэмжлэг үзүүлэх зэрэг асуудлыг орхигдуулж байгаа нь ажиглагдсан. Түүнчлэн хог хаягдал, сав баглаа, боодол болон аялал жуулчлалын салбарын онцлогт тохирсон тусгайлсан бодлогын хэрэгслүүд үгүйлэгдэж байна.

Байгалийн нөөцийг хамгаалах, бохирдол, хог хаягдлаас урьдчилан сэргийлэх, бууруулах талаар мэдээлэл, сургалт, сурталчилгааны бодлого хийгээд иргэдэд чиглэсэн эдийн засгийн урамшуулал, хөнгөлөлтийн эрхзүйн орчин бүрдээгүй. Угтаа ААН-ийн түвшинд мэдээллээр хангах, мэдлэгийг дээшлүүлэх, тогтвортой байдлын соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн ажлуудыг компанийн зайлшгүй авч хэрэгжүүлэх арга хэмжээ болгон хэвшүүлэх шаардлагатай. Эдгээр хүчин чармайлтыг бодлогын бусад хэрэгслүүдтэй уялдуулж, мэргэжлийн холбоод, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах замаар цогц байдлаар хэрэгжүүлэх нь зүйтэй.

БЭЛЭН БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

Нийлүүлэгч талын, ТЭЗ-ийн бэлэн байдлыг 11 үзүүлэлтээр хэмжихэд бизнес эрхлэгчдийн ТЭЗ болон тогтвортой хөгжлийн талаар цогц ойлголт, мэдлэг дутмаг байхын зэрэгцээ, хог хаягдлын менежментэд түлхүү онцгой анхаарал хандуулж байна. Өөрөөр хэлбэл бизнес эрхлэгчид бүтээгдэхүүний ашиглалтын

хугацааг уртасгах, үйлчилгээнд суурилсан бизнесийн загварт шилжих, тойрог нийлүүлэлт рүү шилжих, ТЭЗ-ийн бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлтийг хөнгөвчлөх зэрэг ТЭЗ-ийн бусад стратегиудаас хог хаягдлын менежментийг илүү чухалчлах хандлагатай байна.

Үнэлгээнээс харахад нийлүүлэлт талын (үйлдвэрлэгч болон дундын хэрэглэгчид/үйлчилгээ үзүүлэгч бүлэг) дийлэнх бизнес эрхлэгчид ТЭЗ-ийн стратегийг нэвтрүүлж, ТЭЗ-ийн шийдлүүдийг хэрэгжүүлэхэд бэлэн биш байна. Судалгаа болон ярилцлагын явцад цугларсан мэдээллээс үзэхэд эдгээр бизнесүүдийн ихэнх нь ТЭЗ-ийг нэвтрүүлэх нь ашиг орлогоо нэмэгдүүлэх боломж гэж харахаас илүүтэйгээр ТЭЗ-ийн үйл явцад хөрөнгө оруулах нь санхүүгийн дарамтыг нэмэгдүүлнэ гэж харж байна. ТЭЗ-ийн туршлагыг нэвтрүүлснээр бизнесийн ашиг орлогод эерэг үр нөлөө гарах тухай ойлголт хандлага огт төлөвшөөгүй.

Хэрэглэгчийн талаас нь авч үзвэл, судалгаанд оролцсон аялагчид ТЭЗ-ийн талаар тодорхой хэмжээний мэдлэгтэй ба байгальд үлдэх сөрөг ул мөрийг багасгах, байгальд ээлтэй үйл ажиллагаа явуулах, хүнсний амт чанар, хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах зэрэг тогтвортой аялал жуулчлалыг дэмжих сонирхол өндөр. Хамгийн гол нь жуулчид байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн, үйлчилгээний төлөө илүү төлбөр төлөхөд бэлэн байгаа нь судалгааны үр дүнгээс харагдлаа.

Бэлэн байдлын үнэлгээгээр мөн үйлдвэрлэгч, үйлчилгээ үзүүлэгчид бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ амьдралын мөчлөгийн үешатуудад ТЭЗ-ийг нэвтрүүлэх, ТЭЗ-ийн шийдлүүдийг хэрэгжүүлэхэд тулгарч буй бэрхшээл, боломжуудыг ТЭЗ-ийн стратегиудад тохирсон холбогдох 9R зарчмын дагуу үнэлсэн.

Ерөнхийдөө, үйлдвэрлэгч болон дундын хэрэглэгч (үйлчилгээ үзүүлэгчид) аль аль нь бизнесийн үндсэн үйл ажиллагаа болох худалдан авалт, үйлдвэрлэл, борлуулалт, маркетинг зэрэгт түлхүү

анхаарал хандуулдаг ч үйлдвэрлэлийн хүрээнээс гадуурх бүтээгдэхүүний дизайн, хэрэглээний дараах үе шатан дахь оролцоо бага. Бизнес эрхлэгчид бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ амьдралын мөчлөгийн бүх үе шатанд оролцохгүй бол бүтээгдэхүүн (үйлчилгээ)-ний үе шат бүрд эдийн засаг, байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийг үнэлэхэд хүндрэлтэй болж, дизайн болон хэрэглээний дараах үе шатанд ойлголтын зөрүү гарах магадлалтай. Үүний улмаас ТЭЗ-ийн боломжит шийдлүүдийг анзааралгүй өнгөрч, цогц байдлаар хөгжүүлэх боломж хумигдах магадлалтай.

Үйлдвэрлэгч болон үйлчилгээ үзүүлэгчид (дундын хэрэглэгчид)-тэй хийсэн ярилцлага болон судалгааны дүнгээс харахад бизнес эрхлэгчид “нөөцийн үр ашгийг нэмэгдүүлэх” стратегийн хүрээнд нөөцийг хэмнэх талаар сайн ойлголттой байна. Тэд нөөц ба эрчим хүчний хэмнэлтийн талаар тодорхой мэдлэгтэйгээс гадна ялангуяа хуванцар хог хаягдлын хувьд “тэг хаягдал”-ын зарчмыг тууштай баримталж, тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацааг уртасгахад анхаарал хандуулж, нөөцийн үр ашиг, цэвэр үйлдвэрлэлийн талаар тодорхой мэдлэг туршлагатай болох нь харагдсан. Мөн тэд түлш, цахилгаан зарцуулалтыг бууруулахын тулд эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийг идэвхтэй ашигладаг.

“Бүтээгдэхүүний ашиглалтын хугацааг уртасгах” стратегийн хүрээнд, бизнес эрхлэгчдийн хоёр бүлэг аль аль нь тоног төхөөрөмжөө засварлах, “тэг хаягдал”-ын бодлогыг хэрэгжүүлэх зэрэг олон шийдлийг хэрэгжүүлжээ. Гэвч сав баглаа боодлыг дахин боловсруулах, дахин ашиглахад сорилт тулгарсаар байна.

ТЭЗ-ийн чухал нэг бүрэлдэхүүн хэсэг нь бизнесийн шинэ загварууд бий болгох явдал юм. ТЭЗ нь ердийн шугаман бизнесийн загварыг өөрчилж, ялангуяа “үйлчилгээнд суурилсан загварт шилжих” явдал түгээмэл байдаг. Энэхүү бизнесийн шинэ загвар нь бизнес эрхлэгчдийн хувьд шинэ ойлголт тул судалгаанд оролцогчдод ойлгомжгүй байсан байх магадлалтай. ТЭЗ-ийн бизнесийн бусад загварт шаардлагатай нөөц, тоног төхөөрөмжөө хуваалцах буюу дундаа ашиглах, түрээслэх ойлголтууд мөн багтана. Тоног төхөөрөмжөө хуваалцах нь эдгээр салбарын бизнес эрхлэгчдийн дунд хамгийн өргөн хэрэглэгддэг бизнесийн загвар аж.

“Хаягдлын дараа нөхөн сэргээх” стратеги нь нөөцийг тойрогт эргэлдүүлэх зорилготой ба бизнес эрхлэгчдийн 50% гаруй нь хог хаягдлын менежментийн зохицуулалттай. Гэвч одоогийн байдлаар хог хаягдлын дийлэнх нь хогийн цэгт хаягдаж байгаа нь ТЭЗ-ийн оновчтой шийдэлд тооцогдохгүй.

“Тойрог нийлүүлэлт рүү шилжих” стратеги нь бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлүүлэлтийн сүлжээг өөрчлөхөд чиглэх ба энэ нь түүхий эд, нөөц төдийгүй эрчим хүчний эх үүсвэрийг хамарна. Бизнес эрхлэгчид нийлүүлэлтийн эх үүсвэрийн талаар зохих түвшний мэдлэгтэй байгаа нь тэд илүү тогтвортой орц материал ашиглах, байгальд ээлтэй нөөц, эрчим хүчний хэрэглээ рүү шилжих хүсэлтэй байна. Тэд байгаль орчинд ээлтэй, ногоон буюу хог хаягдалгүй орц материал, ялангуяа органик хүнсийг чухалчилж авч үздэг. Гэвч сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр зэрэг тогтвортой шийдлүүд хязгаарлагдмал байдаг нь бизнес эрхлэгчид тойрог зарчмыг баримталдаг нийлүүлэгч нараас түүхий эд, нөөцөө бүрэн хангахад хүндрэлтэй байж болох юм.

“Тойрог бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлтийг дэмжих” стратеги нь ханган нийлүүлэгчдийн зүгээс хэрэглэгчдээ мэдээллээр хангаж, санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ тогтвортой байдлын талаар сурталчлахад түлхүү анхаардаг. Ханган нийлүүлэгчдээс бүтээгдэхүүн, үйлчилгээнийх нь тогтвортой байдлын талаарх мэдээлэл хүсэх, энэ мэдээллийн талаар түншүүд болон үйлчлүүлэгчидтэйгээ мэдээлэл солилцох нь түгээмэл.

Амьдралын мөчлөгийн янз бүрийн үе шатуудын хувьд бүтээгдэхүүн, үйлчилгээний дизайны үе шатанд бизнес эрхлэгчдийн оролцоо харьцангуй бага бөгөөд дундын хэрэглэгчид/үйлчилгээ үзүүлэгчидтэй харьцуулахад илүү бага. Үйлчилгээ үзүүлэгчид тухайлбал хоолны цэс, порцыг дахин загварчлах, барилга байгууламж барихдаа эрчим хүч, усны хэмнэлттэй тоног төхөөрөмж, шинэ технологийг нэвтрүүлэх зэргээр дизайны шатанд оролцдог. Гэвч бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүн боловсруулах, инноваци шингээх үйл явц түр зуурын бөгөөд тодорхой төлөвлөгөө бүтэцгүй хэрэгжих хандлагатай байна.

9R (татгалзах, дахин бодох, бууруулах, дахин ашиглах, засварлах, дахин үйлдвэрлэх, өөр зориулалтаар дахин ашиглах, дахин боловсруулах, нөхөн сэргээх) зарчмын хувьд ихэнх бизнес эрхлэгчид бууруулах, засварлах, нөхөн сэргээх зарчмуудыг илүүтэй сонирхож байна. Тэр дундаа засварлах, бууруулах, дахин ашиглахад түлхүү анхаарч байна. Энэ нь тэдний нөөцийн хэмнэлт болон цэвэр бүтээгдэхүүний талаар сайн мэддэг, хог хаягдлын менежментийн хэрэгжүүлэх сонирхолтой нь нийцэж байна.

ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ҮНЭЛГЭЭ

Оролцогч талуудын үнэлгээг бизнес эрхлэгчдэд чиглэсэн байдлаар хийж, техникийн зуучлагч, санхүүгийн байгууллага, хөгжлийн байгууллага, салбарын зуучлагч 4 гэж ангилсан 10 төрлийн оролцогч талуудын бүлгийг тодорхойлж, ТЭЗ-ийн таатай орчныг бүрдүүлэхэд тэдний гүйцэтгэж буй үүрэг, оролцоог үнэлэв.

Төрийн байгууллагууд ТЭЗ-т шилжихэд дэмжлэг үзүүлэх бодлогын арга хэрэгсэл, эрхзүйн орчныг бүрдүүлэхэд чухал. Эдгээр оролцогч тал “ТЭЗ” гэсэн нэр томъёог шууд ашиглах албагүй ч ТЭЗ-ийн зарчмуудыг дэмжих бодлого боловсруулах, хууль эрхзүйн орчныг тодорхой болгох үүрэгтэй. Тэд мөн хог хаягдлын менежмент, нөөц ашиглалт, дахин боловсруулалт болон холбогдох салбарын хууль тогтоомжийг батлах үүрэг хүлээдэг. Гэсэн хэдий ч төрийн байгууллагууд бизнес эрхлэгчид, салбарын холбоод, ТББ, судалгааны байгууллагууд зэрэг төрөл бүрийн оролцогч талуудтай ажиллах, тэднийг татан оролцуулахад хүндрэлтэй. Шийдвэр гаргах үйл явцад өргөн хүрээг хамарсан бодлого, туршлагыг харгалзан үзэхийн тулд хүртээмжтэй, оролцоотой хандлагыг баримтлах шаардлагатай. Хэдийгээр хүртээмжтэй, үр дүнтэй бодлогын арга хэрэгсэл, эрхзүйн орчныг бүрдүүлэхэд талуудын оролцоо маш чухал боловч оролцогч талуудын бодлого боловсруулах үйл явцад оролцох боломж хязгаарлагдмал байх магадлалтай. Мөн төрийн байгууллагууд ТЭЗ-ийн судалгаа, хөгжүүлэлтийн санаачилгуудад зориулсан санхүүжилтийн механизм бий болгоход хүндрэлтэй байна. Түүнчлэн судалгаа, хөгжүүлэлтийн ажлыг эрчимжүүлэхэд төрийн байгууллага хоорондын уялдаа холбоо сул байна.

Технологи нийлүүлэгчид болон бизнес эрхлэгчдийн хооронд шууд хамтын ажиллагаа хангалтгүй байна. Харин олон улсын байгууллага, санхүүгийн байгууллагууд энэ чиглэлээр хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдээрээ дамжуулан хамтын ажиллагааг идэвхтэй өрнүүлж байгаа.

Судалгааны хүрээлэнгүүд болон эрдэм шинжилгээний байгууллагууд нь ТЭЗ-ийн мэдлэгийн санг баяжуулах шинжлэх ухааны судалгаа хийж, сургалт явуулах, мэргэжилтнүүдийг бэлтгэхэд чухал үүрэгтэй. Эдгээр оролцогч талууд ЖДҮ, засгийн газрын агентлагууд болон бусад талуудтай хамтран мэдлэг туршлагаа хуваалцах, заавар зөвлөгөө өгөх, ТЭЗ-ийн санаачилгуудыг дэмжих зэргээр хамтран ажиллах боломжтой. Гэвч эрдэм шинжилгээний байгууллагуудын дунд ТЭЗ-тай холбоотой үйл ажиллагаа, туршлага одоогоор хязгаарлагдмал.

Олон улсын байгууллагууд өргөн хүрээтэй мэдээлэл сурталчилгааны кампанит ажил, чадавхыг бэхжүүлэх санаачилгыг хэрэгжүүлэх үүднээс Засгийн газар, ТББ, бизнес эрхлэгчидтэй идэвхтэй хамтран ажилладаг. Гэвч одоогоор аялал жуулчлалын салбардахь ТЭЗ-ийн үйл явцыг ахиулахуйц шилдэг туршлагыг оролцогч талуудтай хуваалцах хамтын ажиллагааг дэмжсэн харилцаа хязгаарлагдмал байна. Аялал жуулчлалын салбарт ТЭЗ-тай холбоотой олон нийтийн арга хэмжээ, сургалт зөвлөгөөн, боловсролын талын санаачилгууд хэрэгжиж эхлээгүй. Мөн ТЭЗ-ийн талаар холбогдох мэдээлэл, кейс судалгаа, удирдамж, арга зүй, бодлого зэрэг мэдээллийг авч болох вэбсайт, портал, мэдээллийн төвүүд хомс байна.




ДОЛОО. ЗӨВЛӨМЖ

Зорилго, зорилтуудаа илүү нарийн тодорхойлж, тэдгээрт хүрэх арга замуудыг боловсруулах нь Монгол Улсын аялал жуулчлал, түүнтэй холбогдох салбаруудад (хүнс, ус ундаа, сав баглаа боодол) ТЭЗ-ийг нэвтрүүлэх үндэс суурь болно. Ийнхүү стратегийн алхмуудыг авч хэрэгжүүлснээр илүү тогтвортой, тойрог хэлбэрийн аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх үндэс суурь тавигдаж, Монгол Улсад тогтвортой аялал жуулчлалыг цогцоор нь хөгжүүлэх улс төрийн чиглэлийг тодорхойлох сайн жишээ гарч ирэх боломжтой. Эдгээр шийдлүүдийг үндэсний болон орон нутгийн нөхцөлд тохируулан боловсруулахын зэрэгцээ бусад улс

орны ТЭЗ-ийн туршлагаас санаа авахыг зөвлөж байна. ТЭЗ-ийн санаачилгуудыг хэрэгжүүлэхийн тулд холбогдох оролцогч талуудын хамтын ажиллагаа чухал үүрэгтэй ба энэхүү үйл явцын туршид инновацыг нэн тэргүүнд авч үзэх нь чухал.

Энэ бүлэгт өгүүлсэн зөвлөмжүүд нь **(Зураг 6)**-т харуулсны дагуу ТЭЗ-ийн таатай орчныг бүрдүүлэх хүчин зүйлсэд үндэслэсэн. Эдгээр зөвлөмжийг үндэсний бодлого стратеги болон салбар (аялал жуулчлал, хоол хүнс, сав баглаа боодол, хог хаягдлын менежментийн салбар)-ын онцлог, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн боловсруулсан.

Зураг 6. ТЭЗ-ийн таатай орчныг бүрдүүлэх хүчин зүйлс



(Хүснэгт 4)-д бодлогын арга хэрэгсэл, эрхзүйн орчныг боловсронгуй болгох санаачилга бүхий стратегийн замын зураглалыг үзүүлэв. Үүнд аялал жуулчлалын салбарт тохирсон үндэсний стратегийг тодорхойлох, холбогдох салбаруудад үндэсний томоохон зорилтуудыг дэвшүүлэх, тогтвортой аялал жуулчлалын стандартыг бий болгох зэрэг гол арга хэмжээнүүдийг тоймлон харуулсан. Мөн

энэхүү зөвлөмж нь эрчим хүчний үр ашгийн шалгуур, хог хаягдлын менежмент, сав баглаа боодлын зохицуулалт, талуудын оролцоо зэрэг чухал асуудлыг хөндсөн ба өргөн хүрээг хамарсан. Эдгээр зөвлөмж нь Монгол Улсын хөгжлийн бодлогыг ногоон хөгжлийн зорилтуудтай уялдуулж, бүх оролцогч талуудын хүртээмжтэй оролцоог дэмжих зорилготой.

Хүснэгт 4. Монгол Улсын аялал жуулчлалын салбарт ТЭЗ-ийг нэвтрүүлэх бодлогын зөвлөмж

Салбар/ Ангилал	Бодлогын арга хэрэгсэл/Эрхзүйн орчин
Ерөнхий	- Аялал жуулчлалын салбар дахь ТЭЗ-ийн үндэсний стратегийг тодорхойлох. Түүнд суурилсан салбар дундын зорилтуудыг үндэсний хэмжээнд дэвшүүлэх. - Нэн тэргүүний хэрэгцээ шаардлага, байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл зэрэг тэргүүлэх үзүүлэлтүүдэд үндэслэн холбогдох салбаруудад зориулсан үндэсний стратеги боловсруулах.
Аялал жуулчлал	- Аялал жуулчлалын салбарт ТЭЗ-ийн туршлагыг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор үндэсний хэмжээнд цогц бодлого, эрхзүйн зохицуулалтыг бий болгох. - Тогтвортой аялал жуулчлалын стандарт бий болгох.
Хүнс, ус ундаа	- Эрчим хүчний хэмнэлттэй холбоотой зорилтуудыг хангах шалгуур болон энэ төрлийн төслүүдийн хэрэгжилтийг үнэлэх шалгуурыг тогтоох. - Зайнаас болон газар дээрх хяналтыг хослуулан хүнс, хөдөө аж ахуйн зохистой дадлын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийх арга хэрэгслийг тодорхойлох. - ТЭЗ-ийн 9R зарчмын стандартчилал, хэмжилттэй холбоотой шаардлагыг тусгах замаар Монгол Улсын ногоон хөгжлийн зорилтуудтай уялдуулах, хүнс, хөдөө аж ахуйн салбарын шилдэг 100 үйлдвэрлэгчийг шалгаруулж, урамшуулах журамд хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн сайн туршлагыг стандартчилах.
Сав баглаа, боодол	- Сав баглаа боодлын хувьд "Үйлдвэрлэгчийн өргөтгөсөн хариуцлагын тогтолцоо"-г (Extended Producer Responsibility - EPR) бий болгох. - Бүх төрлийн нэг удаагийн болон удаан эдэлгээгүй сав баглаа боодлыг хориглох, өөр бүтээгдэхүүнээр оруулахад анхаарах. - Нэг удаагийн нийлэг уутыг импортлохгүй байх бодлогыг чангатгах. - Сав баглаа боодлын салбар хувьд ТЭЗ-ийн бодлогыг тодорхойлж, түүний дагуу шошго, үйлдвэрлэлийн стандартыг боловсруулах.
Хог хаягдлын менежмент	"Бохирдуулагч нь төлөх" зарчим, эко төлбөрийн тухай хууль эрхзүйн зохицуулалтыг шаардлагатай журам стандартын хамт боловсруулж, хэрэгжилтийг хангах.
Оролцогч талууд	- Зохицуулалтын орчинд оролцогч талуудад хүндрэл учруулдаг хуулийн давхардал, хийдлийг арилгах үүднээс бодлого, эрхзүйн баримт бичгүүдийг хооронд нь уялдуулах - Бодлого боловсруулах үйл явцад бизнес эрхлэгчид, салбарын холбоод, ТББ-уудын оролцоог нэмэгдүүлэхийн тулд хүртээмжтэй, оролцоотой орчин бүрдүүлэх.

Салбар/ Ангилал	Технологи
Ерөнхий	- ТЭЗ-ийн шилжилтийг дэмжихийн тулд их өгөгдөл, хиймэл оюун ухаан (AI), блокчэйн болон зүйлсийн интернэт (IoT) зэрэг шинээр гарч ирж буй дижитал технологиудыг (шинэ бизнесийн загваруудтай хослуулан) ашиглах. - Нөөцийн үр ашгийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахын тулд шинэ технологийг үйлдвэрлэлд ашиглах.
Аялал жуулчлал	Эрчим хүчний хэмнэлттэй төхөөрөмж ашиглах Суурийг тавих үе шатнаас эхлээд сайн технологийг ашиглах.
Хүнс, ус ундаа	Хүнс, ундааны үйлдвэрлэлд ашиглах боломжтой шилдэг техникүүдийг нэвтрүүлэх.
Сав баглаа, боодол	Сав баглаа боодлыг дахин ашиглах, сав баглаа боодлыг сэргээх болон бусад ижил төстэй арга хэмжээг дэмжихийн тулд савлагааны төрлийг багасгаж, стандартчилах.
Хог хаягдлын менежмент	- Одоо байгаа хог хаягдлын менежмент, дахин боловсруулах байгууламжуудын тогтвортой байдлыг хангах. - Хог хаягдлыг дахин боловсруулах шинэ байгууламжуудыг барих. - Нөөцийг сэргээх шинэ технологийг нэвтрүүлэх.
Оролцогч талууд	Бизнес эрхлэгчид болон технологи нийлүүлэгчдийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх.

Салбар/ Ангилал	Чадавхыг бэхжүүлэх (Мэдлэг туршлага солилцох, Түншлэл ба хамтын ажиллагаа, Сурталчилгаа, Мэдээлэл)
Ерөнхий	- Оролцогч талуудын дунд ТЭЗ-ийн ашиг тус, аялал жуулчлалын салбарын тогтвортой байдлын ач холбогдлын талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлж, харилцааг сайжруулах. Сурталчилгааны кампанит ажил, сургалт зөвлөгөөн зохион байгуулж, мэдээлэл түгээх сувгуудыг хөгжүүлэх. - Хэрэгжилтийн үр дүн, нөлөөллийн үнэлгээг олон нийтэд танилцуулах.
Оролцогч талууд	- Мэдлэг туршлага хуваалцах, чадавхыг бэхжүүлэх, ТЭЗ-ийн туршлагыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор оролцогч талуудын хамтын ажиллагаа, түншлэлийг дэмжих. Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх нэгдсэн арга барицыг бий болгохын тулд оролцогч талуудын харилцаа холбоо, хамтын ажиллагааг дэмжих. - Байгальд ээлтэй савлагааны технологийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэхийн тулд технологи нийлүүлэгчид болон бизнес эрхлэгчдийн шууд хамтын ажиллагаа, түншлэлийг дэмжих. - Аялал жуулчлалын салбарын бизнес эрхлэгчидэд тохирсон ТЭЗ-ийн туршлагын талаар сургалтын хөтөлбөр боловсруулах замаар оролцогч талуудын туршлага, мэдлэгийг дээшлүүлэх. - Оролцогч талуудын дунд мэдлэг, мэдээлэл, харилцаа хамтын ажиллагааг нэмэгдүүлэх. ТЭЗ-ийн туршлагыг нэвтрүүлэх, тогтвортой байдлын соёлыг төлөвшүүлэхийн тулд харилцааны кампанит ажил, семинар, мэдээлэл түгээх сувгуудыг хөгжүүлэх. - Олон улсын байгууллага, санхүүгийн байгууллагууд, технологи нийлүүлэгчдийн хоорондын түншлэл, мэдлэг туршлага солилцох явдлыг дэмжих.

Салбар/ Ангилал	Салбар/Судалгаа ба хөгжүүлэлт
Ерөнхий	ТЭЗ-ийн чиглэлээр судалгааны төслүүдийг санхүүжүүлэх боломжийг нэмэгдүүлж, байгууллага хоорондын уялдаа холбоог сайжруулах.
Аялал жуулчлал	Орон нутгийн иргэдийн оролцоотой шинэ төрлийн аялал жуулчлал хөгжүүлэх.
Хүнс, ус ундаа	Дотоодын орц найрлага бүхий шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх.
Сав баглаа, боодол	Шинэ, байгальд задардаг, байгалийн гаралтай, ургамалд суурилсан сав баглаа боодлын материал, сав баглаа боодол үйлдвэрлэл, хог хаягдлын мэдээлэл, тоног төхөөрөмжийн чиглэлээр хийгдэх судалгааны ажлыг дэмжих.
Хог хаягдлын менежмент	Цуглуулах, ангилах, дахин боловсруулалтыг нэмэгдүүлэх технологийн шинэчлэлийг дэмжих.
Оролцогч тал	- Томоохон үйлдвэрүүд болон бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагаа, түншлэх боломжийг дэмжих, ТЭЗ-ийн сорилтуудыг шийдвэрлэх шинэ технологи, бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор мэдлэг туршлага солилцох чадавхыг нэмэгдүүлэх. - ТЭЗ-ийн туршлагыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор эрдэм шинжилгээний байгууллагуудыг судалгаа, мэдлэг туршлагаа хуваалцах үйл явцад татан оролцуулах. - Эрдэм шинжилгээний байгууллагууд сургалт, мэдээлэл, судалгааны хүрээнд бизнес эрхлэгчидтэй түншлэх замаар ТЭЗ-тай холбоотой үйл ажиллагаанд оролцоогоо нэмэгдүүлэх. Төрийн байгууллагууд мэдлэг туршлага солилцох платформыг хөгжүүлж, эрдэм шинжилгээний байгууллагуудын ТЭЗ-ийн санаачилга дахь оролцоог дэмжих.

Салбар/ Ангилал	Санхүүгийн үйлчилгээ/Зах зээлийг идэвхжүүлэх
Ерөнхий	- Бизнес эрхлэгчдийг ТЭЗ-т шилжихэд дэмжлэг үзүүлэхийн тулд санхүүгийн урамшуулал, буцалтгүй тусламж, татаас зэрэг тодорхой дэмжлэг, урамшууллын механизмыг ашиг сонирхол, нөлөө өндөр оролцогч талуудтай хамтран бий болгох. - Бизнес эрхлэгчидэд ТЭЗ-ийн технологи нэвтрүүлэх, сайжруулахад хөрөнгө оруулах тусгайлан санхүүжилтийн хувилбаруудыг боловсруулахад нь үндэсний болон олон улсын санхүүгийн байгууллагууд дэмжлэг үзүүлэх. Бизнес эрхлэгчдийн тусгай хэрэгцээнд нийцсэн ногоон зээл, санхүүгийн бүтээгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлэх.
Аялал жуулчлал	Зээл олгохдоо ТЭЗ-тай холбоотой заалтыг нэмж оруулах (жишээ нь, зээлийн хугацаанд байгаль орчны болон ТЭЗ-ийн үндсэн зарчмуудыг хэрэгжүүлэх, гэх мэт).
Хүнс, ус ундаа	- Салбарыг дэмжих чиглэлээр олгож буй хөнгөлөлт, урамшуулалд тодорхой квот тогтоож, эдийн засгийн хөгжлийн зарчмыг хэрэгжүүлсэн ААН-үүдийг хөнгөлөлтөөр урамшуулах. - Дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг дэмжиж, импортын бүтээгдэхүүнтэй өрсөлдөхүйц үнийн тэнцвэрийг бий болгох, үүнд татварын янз бүрийн хөнгөлөлт үзүүлэх, тодорхой бүтээгдэхүүнийг татвараас чөлөөлөх, эсвэл тухайн бүтээгдэхүүнд татаас олгох.
Сав баглаа, боодол	Дотооддоо үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг дэмжиж, импортын бүтээгдэхүүнтэй өрсөлдөхүйц үнийн тэнцвэрийг бий болгох.
Хог хаягдлын менежмент	Орон нутгийн хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхийн тулд нэмэлтээр үүсэх зардлуудыг НӨАТ, гаалийн татвараас чөлөөлөх, эсвэл үйлдвэрлэлийн хэмжээнээс хамаарч төрөөс урамшуулал, дэмжлэг олгох.



301, Бага тойруу, 5-р хороо,
Сүхбаатар дүүрэг, 14200,
Улаанбаатар хот, Монгол улс



46А/265 Улаанбаатар, Монгол



www.irim.mn



IRIMongolia



[irim_mongolia](https://twitter.com/irim_mongolia)



[irim_mongolia](https://www.instagram.com/irim_mongolia)



+976-7011-7101



contact@irim.mn